

Бөхөнгийн экологи болон хамгаалалтай холбоотой мэдээлэл, санал бодлоо солилцох зургаан хэл дээрх хэвлэл

Агуулга

Үндсэн өгүүллэг

Б. Чимэддорж, Л.Амгалан, Б. Бүүвэйбаатар
Монгол бөхөнгийн (*Saiga tatarica mongolica*) тархац, өнөөгийн төлөв байдал **1**

Мэдээ **2**

Эрдэм шинжилгээний өгүүллэгүүд

Дж. К. Янг, Б.Бүүвэйбаатар, А.Е. Файн, Б.Лхагвасүрэн, Дж.Бергер
Бөхөнгийн янзага барих тэмдэглэх **8**

Б.Чимэддорж
Монголд бөхөн хамгаалах төслийн хүрээнд мэдээллийн тогтолцоог сайжруулах шаардлагын үнэлгээ **9**

Х. О'Нилл, Х.Манджиев, Э.Дж. Милнер-Гулланд
Байгаль хамгаалагч нарын оролцоотой баруун хойд Прикаспийн бөхөнгийн популяцийн мониторинг **10**

Элизабет Уайтбред, Диана Обгенова, Э.Дж.Милнер-Гулланд
Халимагт хийсэн хамтын мониторингийн чадавхийн үнэлгээ **12**

Быкова Е.А., Есипов А.В., Черногаев Е.А.
Узбекистан дахь үржлийнхээ хуучин нутаг руу бөхөн буцаж ирэх болов уу? **13**

Алтай Жатканбаев
Казахстаны өмнө зүгт Арыск-Карактаускийн дархан газрын бүсэд бөхөнтэй (*Saiga tatarica tatarica*) тааралдсан тухай **15**

Черноок В.И
Бөхөнгийн тоологдод дулааны мэдрэмж бүхий агаараас авсан зургийг хэрэглэх нь **15**

Вадим Санжеев
“Яшкульский” үржүүлгийн газар дахь энергийн элдэв эх үүсвэрүүд **16**

Төслүүдийн тойм
Бөхөн хамгаалах альянсийн 2008 оны жижиг төслүүдийн хөтөлбөрийн ялагчид тодорлоо! **17**

Шинэ хэвлэлүүд **18**

Манай байгууллагын гишүүд **19**

Зарлал
Биологич-агнуурзүйдийн олон улсын ХХХХ конгресс Москва хотноо болно. **19**

Бөхөн хамгаалах харилцан ойлголцлын санамж бичгийн (MoB) гүйцэтгэлийн тухай SCA
2006 оны 9-р сараас 2008 оны 10-р сар хүртлэх хугацаанд CMS-ийн бөхөн хамгаалах MoB-ийн гүйцэтгэлийн тайлан **20**

Монгол бөхөнгийн (*Saiga tatarica mongolica*) тархац, өнөөгийн төлөв байдал

Б. Чимэддорж¹, Л.Амгалан², Б. Бүүвэйбаатар²

¹Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, ²Биологийн хүрээлэн, ШУА, chimeddorj@wwf.mn

Монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*) бол Монгол орны унаган бөгөөд улаан номонд (1987) орсон цөөн зүйл туруутаны нэг юм. Энэ зүйлийн биологи, экологи, хамгааллын асуудлыг олон эрдэмтэн судалж байсан (Банников, 1954; Эргэдэнэдагва, 1954; Дуламцэрэн, Амгалан 1995; Лушечкина нар, 1999).



Монгол бөхөнгийн янзага. Зургийг Б.Чимэддорж

Биологийн хүрээлэн², Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар¹, орон нутгийн байгаль хамгаалагч нар хамтран бөхөнгийн сүргийн тооллого судалгааг хийлээ. Байрзүйн зураг ашиглан Шаргын говь, Хүйсийн говь, Дөргөний хүрэн тал, Манханы нутаг дэвсгэрт 2 км болгонд параллель байдлаар замналууд сонгон авсан. Бөхөнгийн нөөцийн үнэлгээг нийтлэг хэрэглэдэг шулуун замналын тооллогын аргаар гүйцэтгэсэн. Шарга, Хүйсийн говь, Дөргөний хүрэн талд 282 сүргийн

1829 бодгаль бөхөн үзэж тэмдэглэсэн. 282 сүргээс 5 хүртлэх бодгальтай сүрэг 62.05 % (n=175) хувийг, 10 хүртэл бодгальтай сүрэг 24.1 % (n=68) хувийг, үлдсэн сүргүүд нь 10-аас дээш бодгальтай байв. Тархацын 13000 км² талбай бүхий нутагт 3240 бөхөн байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 11.8%-иар өссөн болохыг харуулж байна (хүснэгт).

Хүснэгт

Монгол бөхөнгийн популяцийн нягтшил, тооны үнэлгээ

Газрын нэр	тоо, бодгаль		нягтшил, бодгаль/1000 га	
	1-р сар 2007	1-р сар 2008		1-р сар 2007
Шаргийн Говь	761	1979	Шаргийн Говь	761
Хүйсийн Говь	2024	1107	Хүйсийн Говь	2024
Дөргөн	60	154	Дөргөн	60
Манхан	15	ND	Манхан	15
Бүгд	2860	3240	Бүгд	2860

ND – мэдээлэл байхгүй

Үргэлжлэл дараагын нүүрт.

Эрхлэн гаргагчид. China: Dr A. Kang, WCS China (ygling@online.sh.cn) & Dr Li Lishu, WCN-China (lli@wcs.org); Kazakhstan: Professor A. Bekenov & Dr Iu.A. Grachev, Institute of Zoology (terio@nursat.kz); Mongolia: Dr B. Lhagvasuren, Institute of Biology (ecolab@magicnet.mn) & Yo.Onon, WWF-Mongolia (mpo-species@wwf.mn); Russia: Professor Yu. Arylov, Centre for Wild Animals of the Republic of Kalmykia (kalmisaigak@elista.ru) & Dr A. Lushchekina, Institute of Ecology & Evolution (rusmabcom@gmail.com); Turkmenistan: Dr. D.Saparmuradov, National Institute of Deserts, Plants and Animals (saparmuradov@mail.ru); Uzbekistan: Dr E. Bykova & Dr A. Esipov, Institute of Zoology (esipov@sarkor.uz); UK: Dr E.J. Milner-Gulland, Imperial College London (e.j.milner-gulland@imperial.ac.uk).

Манай хэвлэлийн зургаан хэлний аль нэг дээр аливаа санал хүсэлтийг esipov@sarkor.uz,

saigaconservationalliance@yahoo.co.uk хаягуудаар, эсвэл дээрх гишүүдийн дурын хаягаар хүлээн авна. Жилд хоёр дугаар гарна

Хэвлэлийн эхийг pdf хэлбэрээр, Хятад, Англи, Казах, Монгол, Орос, Узбек хэлдээр www.saiga-conservation.com, <http://saigak.biodiversity.ru/publications.html>, www.iccs.org.uk/saiganews.htm, <http://www.wildlifewardens.net/wcs/mini/Saiga-Chinese.pdf> хаягуудаар авч болно.

Хэвлэлийг санхүүжүүлэгч:



FRANKFURT
ZOOLOGICAL
SOCIETY


Нэмэлт WWF санхүүжилтийг:





Үргэлжлэл өмнөх нүүрт:

Өвлийн улиралд бөхөнгийн хамгийн их нягтшил Шаргийн говьд тэмдэглэсэн байна. Энэ үед бөхөнгүүд цас багатай газруудыг бараадаж байв. Бөхөнгийн популяцийн тоо толгой байнга өөрчлөгдөж байна (зураг). Олон судлаачид янз бүрийн арга зүй ашиглаж байсан боловч тоо толгойн өөрчлөлтийн ерөнхий хандлагыг таньж болно. Бөхөнгийн популяци 1998 оноос эхлэн өсч, 2000 онд 5000 бодгаль бүхий болтлоо өссөн байна. Гэвч зудтай хүйтэн өвлүүд нүүрлэж, хуурай улирал ихэссэнээр 2001-2002 онуудад 750 бодгаль болтлоо буурчээ. 2005 он гэхэд популяцийн хэмжээ ойролцоогоор 1500 бодгаль болон сэргэжээ (Амгалан, 2005).



Зураг. Монгол бөхөнгийн популяцийн динамик

Манханы сүргүүд 1982 онд 130 бодгальтай байснаа 1983-1984 онуудад зуданд нэрвэгдэн 30-аас бага бодгальтай, 1993 онд ойролцоогоор 70 бодгаль, 1998 онд ойролцоогоор 50 болтлоо буурчээ (Shar, 1998). Бидний судалгаагаар энэ хэсгийн бөхөнгийн тоо үргэлжлэн буурсаар байгаа бөгөөд 2008 оны байдлаар ердөө л 15 бодгаль байна (зураг).

Монголд бөхөн аюулд бас л нэрвэгдээд байгааг эдгээр үр дүнгүүд өгүүлж байна. Онгоц ашиглан монгол бөхөнгийн популяцийн бүрэн судалгааг явуулах хэрэгтэй ба тархацын бүх хэсэгт хулгайн антай тэмцэхэд санхүүжилт шаардлагатай байна. Түүнээс гадна, монгол дахь бөхөнгийн популяцийн динамикт уур амьсгалын нөлөөг судлахын тулд байгаль хамгаалагч нар цаг агаарын мэдээг цуглуулахад анхаарал хандуулах хэрэгтэй болж байна.

Энэ судалгаа Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр хийгддэг. Нэмэлт санхүүжилтийг MAVA сангаас авсан. Энэ судалгаа амжилттай гүйцэтгэхэд байгаль хамгаалагч нар маш сайн ажиллаж, туслаж байв. Бидэнд тусламж дэмжлэг үзүүлсэн байгууллага болон хүмүүст, ялангуяа Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Ховд дахь салбарын захирал Цэвэрнравдан гуайд талархаж байна.

Мэдээ

“Бөхөнгийн мэдээ” шагнал авлаа!



Ташкент хотноо 12-р сарын 20-нд

Узбекистаны экологийн сэтгүүлүүдийн уралдааны дүн гарав. Уралдааныг экологийн сэтгүүлийг хөгжүүлэх, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, тогтвортой ашиглалтын асуудалд олон нийтийн мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх зорилготойгоор явуулдаг. Уралдааныг зохион байгуулахад Узбекистаны байгаль орчны улсын хороо, Узбекистаны экологийн хөдөлгөөн, Экофорум, экологийн чиглэлээрх хэвлэлийн компани «Чинор ЭНК» байгууллагууд оролцов. Видеофильм, телевиз болон радиогийн нэвтрүүлгүүд, мэдээллийн баримтууд, фотосурвалжлага, өгүүлэг, экологийн номууд гэх мэт экологийн сэдэвтэй 80 гаруй бүтээлүүд тавигдсан байлаа. «Хамгийн сайн экологийн хэвлэл» гэсэн номинацид *Saiga News* сэтгүүл тэргүүн байр эзэлжээ. Уралдааны ялагчид болон шагналтнуудыг экосэтгүүлчдийн олон улсын уралдаанд оролцохоор сайшаагджээ. Илүү дэлгэрэнгүйг www.eco.uz, www.ecoforum.uz сайтнаас үзнэ үү.



Бидний сэтгүүл яллаа!

Зургийг А.Есупов

Алмата хотод болсон бөхөнгийн зөвлөлгөөн

Алмата хотноо 10-р сарын 29-31 хооронд бөхөн хамгаалах холбооны зөвлөлгөөн боллоо. Эхний өдөр бөхөн хамгаалах дунд хугацааны олон улсын ажлын хөтөлбөрийн гүйцэтгэлийг үнэлэх хурлыг хийлээ (хөтөлбөрийг дараах сайтнаас олж болно www.saiga-conservation.com). Хөтөлбөрийн зүйл тус бүрт бөхөнд шийдвэрлэх ач холбогдол бүхий, 1-2 жилийн дотор шийдэгдсэн байх ёстой А1 ангиллын ажлуудын гүйцэтгэлд үнэлгээ хийсэн. Шинэ сонирхсон байгууллагууд оролцож байгаатай холбогдуулан олон шинэ мэдээллийг нэмсэн байлаа. Тиймээс бидэнд одоо ямар амжилтанд хүрсэн талаар сайн ойлголт бий боллоо.

Хоёрдох өдөр нь «Бөхөнгийн мониторинг – амжилттай туршлагаасаа солилцох нь» нэртэй эрдэм шинжилгээний хурал хийсэн. Бөхөн тархсан улс орны эрдэмтэд мониторингийн хөтөлбөрүүдийн тухай, байгаль хамгаалагч, байцаагч, нутгийн

иргэд (нөхөрлөлийн мониторинг), агаарын тооллого, сансрын болон радио тэмдэглэгээтэй судалгааны тухай ярилаа. Энэ нь бөхөн хамгаалах талаар ажилладаг хүн болгонд янз бүрийн арга зүйн дэвшилттэй болон дутагдалтай талуудын тухай шинэ мэдээллийг авах сайхан боломжыг бүрдүүлж өгсөн.

Сүүлчийн өдөр нь бөхөн хамгаалах холбооны удирдах зөвлөлийн ээлжит хурал боллоо. Хоёр жилийн хугацаанд тус холбоо урт замыг туулсан бөгөөд бидэнд маш олон асуудлыг хэлэлцэх хэрэгтэй байлаа. 2007 онд жижиг төслийн хөтөлбөрийн ялагчид төсөл авсан цагаасаа эхлэн өөрсдийн ололтын тухай өгүүлж, 2008 оны ялагчдад төслийг олгохоор шийдвэрлэлээ (цааш үзнэ үү). Бусад асуудлын хүрээнд, 2009 оны жижиг төслийн хөтөлбөрийг хэлэлцэх, вебсайт болон *Бөхөнгийн мэдээ сэтгүүлийн* санхүүжилтийг олох чиглэлээ



Бөхөн хамгаалах холбооны 2-р зөвлөлгөөний оролцогчи. Алматы хот, 2008 оны 10-р сар.



Бөхөн хамгаалах холбооны удирдах зөвлөлийн гишүүд. Зургийг А.Есинов.

хэрхэн сайжруулах, түүний худалдаа, борлуулалт, Узбекистан болон Халимагт холбооны салбаруудын үйл ажиллагааны тухай, мөн зэрлэг анмтан хамгаалах сүлжээний үзэсгэлэнгийн тухай ярилцлаа (энэ тухай энэ дугаар дээр дэлгэрэнгүй уншиж болно).

Энэхүү хуралд оролцож өөрсдийн ажлаа танилцуулсан болон

хурлыг санхүүжүүлсэн нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенци, Лондонгийн хааны нийгэмлэг, зэрлэг амьтан хамгаалах сүлжээ (ЗАХС) зэрэг байгууллагууд, халуун дотно хүлээн авсан Казахстаны амьтан судлалын хүрээлэнд талархаж байна.

Илүү мэдээлэл авахыг хүсвэл Элизабет Уайтбрэд руу elisabeth.whitebread07@imperial.ac.uk хаягаар хандан уу.

Зэрлэг байгалийг хамгаалах сүлжээний үзэсгэлэн

Элизабет Уайтбрэд

Сан-Франциско хотод 10-р сарын эхээр болсон зэрлэг байгалийг хамгаалах сүлжээний энэ жилийн үзэсгэлэнд Елена Быкова, Анна Луцкекина болон миний бие оролцлоо. Хандивлагч нартай уулзахаас өмнө бид арга хэмжээнд оролцож буй бусад хүмүүстэй танилцах гайхалтай боломжыг олгосон 3 хоногийн семинарт суулаа. Энд байгаль хамгаалах салбарын мундаг хүмүүс болох Заан хамгаалах сангийн (Save the Elephants) Иан Дуглас-Гамильтон, Гепард хамгаалах сангийн (Cheetah Conservation Trust) Лори Маркер, ирвэс хамгаалах сангийн (Snow Leopard Conservancy) Родни Джексон зэрэг хүмүүс оролцож байлаа. Ийм гайхалтай хүмүүст бөхөнгөө танилцуулахад надад маш таатай байв.

Семинар надад маш их таалагдсан бөгөөд бид “Google Earth” программыг судлаж, Газар зүйн мэдээллийн системийн зарим шинэ боломжуудын тухай ойлголтуудыг авч, захирлуудын хамгийн сайн зөвлөгөөг хэрхэн тогтоох, «гал асаасан яриаг» хэрхэн бэлдэх өөрөөр хэлбэл 2 минутын дотор хэн нэгнийг танай төслийг санхүүжүүлэхийг хэрхэн ятгах зэргийг ярьж өглөө. Байгаль хамгааллын ажлыг амжилттай хэрэгжүүлэхдээ тооцох чухал бөгөөд ихэнхдээ цаг хугацаа, мөнгө, мэдлэг дутмагаасаа алдчихдаг олон зүйлүүд байдаг ба ЗАХС энэ орхигдсон зүйлийг нөхөх сайхан боломжийг бидэнд олгосон юм.



SCA –ийн баг WCN Экспод-2008. Зургийг Е.Быкова

Баасан гаригийн орой бидний хандивлагч нартай уулзах анхны уулзалт- ЗАХС -ийн үүсгэн байгуулагч Акико Янгийн гэрт сафари стилийн үдэшлэг болсон. Үдэшлэг болсон адууны талбай төлөөлөгч болсон зүйл бүрийн амьтдын дүрслэлтэй майхнуудаар, болон африкийн амьтдын резинен том дүрсүүдээр чимэглэсэн байв. Бидний хуучин танил хандивлагч нартай ярилцан, шинэ хүмүүстэй уулзаж үдэшлэгээс гарах үед бөхөнгийн тухай л гэхэд 4 цаг гаран ярьсан байв!

Дараагийн өдөр нь үзэсгэлэн болсон. Бид бөхөнгийн тухай өгүүлсэн зүйлсүүд, Узбекистан болон Халимагийн чимэглэлийн хийцээр ширээгээ бүрлээ. Хүмүүс бөхөнд анхаарлаа чиглүүлж байсан бөгөөд учир нь ихэнх хүмүүс бөхөнгийн тухай урьд өмнө нь хэзээ ч сонсоогүй байв. Оклендийн амьтны хүрээлэнгийн өсвөрийн багачуудын томоохон баг өнгөрсөн жил үзэсгэлэнд байсан ба хээрийн энэ туруутаны тухай илүү ихийг мэдэхийн тулд эргэж ирэхийг маш их хүсэж байлаа. Нутгийн иргэдтэй ажиллахдаа анхаарсан Еленагийн лекцэнд тэд хамгийн түрүүнд дугаарласан байсан. Бид нийлбэрээрээ 1000 орчим долларт хүрэх бөхөнтэй холбоотой эд зүйлсийг худалдсан ба бөхөнгийн тухай илүү ихийг мэдэхийг хүссэн, түүнийг сэргээхэд туслах гэсэн олон хүмүүстэй хөөрөлдсөн. Энэ хүнд боловч маш ашигтай өдөр байлаа.



Америк орон бөхөнтэй танилцаж байна. Зургийг Е.Быковой



Сүүлийн өдрийг Лос Альтос дахь гүйцэтгэх захирал Чарли Ноузын гэрт хүлээн авалтан дээр өнгөрүүлсэн. Бүх л өдөржин бид зочидтой ярилцаж, идэж ууж, бас дахин ярилцлаа. Оролцогч бүр л өөрийн ажлаа танилцуулахын тулд богинохон яриа өрнүүлж байв. Еленаг түүний өөрийн сургалт боловсролын ажлын үрээр нутгийн нэг иргэн өөрийнхөө хүүг гэр бүлийнхээ бүх гишүүдийг бөхөнгийн мах идэхийг болиулж чадсан тухай түүнд хэлсэнийг хүмүүст ярихад маш сайхан хүлээж авсан.

ЗАХС –ийн ажилчид, сайн дурынхнаас бүрдсэн сайн зохион байгуулалттай, нойр хоолгүй зүтгэлтэй багын ачаар үзэсгэлэн сайн болсон. Энэхүү уулзалтыг явуулж, БХХ-ийн ажлаа танилцуулах, шинэ хандивлагчтай уулзах боломж олгосон тэдэнд би их талархаж байна. Энэхүү хамтын ажиллагаагаар БХХ илүү хүчтэй болох нь эргэлзээнгүй юм. Илүү мэдээлэл авахыг хүсвэл Элизабет Уайтбред руу elisabeth.whitebread07@imperial.ac.uk хаягаар хандан уу.



Сан-Франциско хотод бөхөнгийн тухай лекц, Экспо-2008.

Зургийг М.Варон

Бөхөн хамгаалах салбар дахь олон улсын хамтын ажиллагаа

Халимаг улсын Зэрлэг амьтны төвийн захирал Юрий Ариловичийн урилгаар 2008 оны 10-р сарын эхээр Зүйлийг хамгаалах төвийн (CCSS) баг ОХУ-д ирлээ. Зүйлийг хамгаалах төв CCSS нь бөхөн шиг зүйл амьтдыг хамгаалах судлах чиглэлээр байгуулагдсан америкийн таван амьтны хүрээлэнгүүдийн нэгдэл юм. Багт зэрлэг амьтадтай ажилладаг 2 малын эмч, Колумбын тойрог, Вашингтоны үндэсний амьтны хүрээлэнгийн доктор Нэнси Бедекер, Охайо мужийн Камберлэнд, Вайлдс төвийн доктор Рейчел Вейсс, түүнчлэн амьтан үржүүлэг ба удирдлагын чиглэлээр олон жилийн ажлын туршлагатай 2 мэргэжилтэн – Калифорнийн Сан-Диегогийн амьтны нийгэмлэгийн мэргэжилтэн Рэнди Ричеса, Вайлдс төвийн Дэна Битема нарын бүрэлдэхүүнтэй байв. Энэхүү аялалыг зохион байгуулахад МАБ-ийн Оросын хороо доктор Анна Лушкекина тусалсан.

Элиста хотод Халимагийн их сургууль дээр Ставрополийн хөдөө аж ахуйн улсын их сургуулийн мал эмнэлэгийн сургууль зоотехникийн Халимагийн салбарын ажилчидтай уулзалтаар эхэлсэн. Дараа нь Байгалийн нөөцийн сайдын орлогч Юрий Каминовтой Халимагт бөхөн хамгаалах хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар албан ёсны уулзалт хийсэн. Яаман дээр бөхөн хамгаалах асуудлыг ойлгоход тус болох хэвлэлийн бага хурлыг зохион байгуулсан байсан.



Үржүүлгийн газарт бөхөнгийн физиологийн байдлын судалгаа.

Зургийг Н.Арылова



Юрий Каминовтой уулзсан уулзалт.

Зургийг Н.Арылова

Элиста хотоос Зүйлийг хамгаалах төвийн баг Яшкульский тосгон рүү зэрлэг амьтдын төвийг сонирхохоор хөдөллөө. Энэ аялалын зорилго нь шинэ нойрсуулагч бэлдмэлийн бөхөнд нөлөөлөх үр нөлөөг үнэлэх байв. Багийнхан энэ төвд мал эмнэлгийн төхөөрөмж, багаж, бүр

Охайогийн Маскингамийн коллежоос бэлэглэсэн микроскоп зэргийг амьтдын эрүүл мэндийн үзлэгт цаашид ашиглахаар авчирчээ. Орон нутгийн телевизийн сурвалжлагчдын бүлэг энэ аялалын тухай зураг авсан.

Дараа нь Зүйлийг хамгаалах төвийн баг Степной дархан газар луу захирал Анатолий Хлуднев болон байгаль хамгаалагчдын багтай уулзалдахаар хөдөллөө. Бүгд л зэрлэг байгалийн орчинд бөхөн болон бусад талын амьтдыг ажиглах, байгаль хамгаалагчдын өмнө тулгараад байгаа асуудал, тэдгээрийн боловсролын хөтөлбөрийн тухай илүү ихийг мэдэхээр догдолсон байлаа.

Зүйлийг хамгаалах төвийн баг амьтныг арчлах, хөдөлгөөнгүй болгох, мал эмнэлгийн үзлэгийн тестүүд бүхий зэрлэг амьтны төвд ашиглах сургалтын материалуудыг орос хэл рүү орчуулахаар бэлтгэх болно. Зэрлэг амьтны төвд үржлийн технологийн хөгжлийн нөлөө болон дотоод шүүрлийн талаар Ставрополь хотын мал эмнэлгийн сургуультай хамтран төлөвлөж буй зохиомлоор үр тогтоолгох төсөлтэй төстэй ирээдүйн шинжлэх ухааны судалгааг дэмжихэд сонирхож байлаа.

ОХУ-д бөхөнгийн хамгааллыг дэмжихийн тулд ирээдүйд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийг Зүйлийг хамгаалах төв хайх болно. Дэлгэрэнгүй мэдээллийг авахын тулд Дэну Битем руу хандан уу: djbeetem@yahoo.com

Ташкент хотноо бөхөнгийн агаарын тооллогын аргазүйн хэлэлцүүлэг боллоо

Ташкент хотод 2008 оны 12-р сарын 9-нд Узбекистанд бөхөнгийн агаарын тооллого явуулах аргазүйн техникийн семинар боллоо. Семинарыг Узбекистаны амьтан судлалын хүрээлэн, бөхөн хамгаалах Альянс, Узбекистаны улсын биохианалт шалгалтынхан зохион байгуулсан байв.

Семинарт Узбекистан болон Казахстаны сонирхсон байгууллагуудын төлөөлөгчид оролцсон (Узбекистаны амьтан судлалын хүрээлэн, бөхөн хамгаалах Альянс, Узбекистаны улсын биохианалт шалгалтынхан, Каракалпакстаны байгаль орчны улсын хороо, Узбекистаны дархан газар, цогцолборт газар, Хөдөө аж ахуй, усны яамны ангийн аж ахуйн удирдах төлөөллүүд, Казахстаны амьтан судлалын хүрээлэн). Узбекистаны бөхөнгийн агаарын тооллогын арга руу практикаар чиглэсэн бөхөнгийн мониторинг явуулах туршлагаасаа солилцох, агаарын тооллогод бэлтгэхэд семинарын зорилго оршиж байв. Оролцогчид Узбекистаны янз бүрийн байгууллагуудын хооронд бөхөнгийн мониторинг, Казахстан улсын сонирхсон байгууллагуудтай энэ асуудлаар улс хоорондын хамтын ажиллагааг хүчтэй болгох, бүр бөхөнгийн Устюртийн популяцийг хамгаалах хамтын



Уулзалтын үеэр.

Зургийг А.Есипова

ажиллагааны тухай хоёр талын зөвшилцөлд гарын үсгийг зурахыг түргэвчлэх шаардлагатайг зөвшөөрлөө. Дэлгэрэнгүй мэдээллийг авахын тулд Александр Есипов руу хандан уу: esipov@sarkor.uz

Бөхөн хамгаалалтан дор

“Российская газета” сонинд 2008 оны 9-р сарын 24-нд мэдээлснээр Халимагийн ардын хурлын өнгөрөгч чуулганд гишүүд амьтны аймгийн тухай хуулийг баталжээ. Шинэ хуулийн үндсэн зорилтуудын нэг нь бөхөнгийн үлдсэн тоо

толгойг аврах байв. Бөхөнгүүд бол бүгд найрамдах улсын “брэндүүдийн” нэг бөгөөд “Черные земли” дархан газрын гол хамгаалагдаж буй объект юм. Дэлгэрэнгүйг: <http://www.rg.ru/2008/09/24/reg-jugrossii/sajgaki.html>

Олон улсын уралдааны ялагчдын тоонд бөхөнгийн тухай хүүхэддэйн кино




SEIMAR
SOCIAL FUND



Agip KCO

Оросын хот Оренбургт 2008 оны 10-р сарын сүүлчээр “Бихүн” хүүхэд өсвөр насныханд зориулсан кино болон нийгмийн хөтөлбөрүүдийн хоёрдугаар Евроазийн телевизийн уралдаан боллоо. Шагналын дипломыг Шымкентийн “Анимастер” студийн “Бөхөнгийн тухай тууль” хүүхэддэйн кино авчээ. Шүүгчид хойч үр удамдаа амьтны аймгийн биологийн олон янз байдлыг хамгаалахад гаргаж тавьсан сэдвийн ихээхэн олон нийтийн ач холбогдолтойг тэмдэглэсэн, харин залуу үзэгчид киноны баатруудад халуухан сэтгэл догдолсон. Нэгдүгээр анги дээрээ бөхөнгийн янзаганы тухай эхэлсэн түүх үргэлжлэх болсон байна. “Анимастер” студи хүүхэддэйн киноныхоо хоёрдугаар хэсгийн ажлаа дуусгалаа. Кино зохиолын хамтарсан зохиолчдоор нь Каракалпакстанын (Узбекистан) өөрсдийн жижиг суурингуудын өдөр тутмын амьдралаас хулгайн ангийн тухай мэддэг сурагчид байлаа. Төсөлд худалдааны бус сайн үйлсийн сан “Seimar Social Fund”, “Agip KCO” компани болон Казахстаны ой ангийн аж ахуйн хороо дэмжлэг үзүүлсэн. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл “Анимастер” студийн Махсут Жаримбетовт хандана уу zmaxut@mail.ru





Бөхөнгийн эврийг хууль бусаар хил давуулах гэсэн оролдлогууд

Төмөр замын Забайкальск гаалийн шалгалтын цэг дээр 2008 оны 4-р сарын 19-нд Хятад руу хууль бусаар бөхөнгийн эвэр гаргах гээд саатуулагджээ. Нийт 22.5 кг бүхий 97 эврийг ачааны вагоны толгойд нуусан байна. Хууль бусаар хил давуулах гэсэн нь вагоны машинистийн туслах, ОХУ-ын иргэн байв. Зэрлэг амьтан ургамлын зүйлүүдийг хууль бусаар хил давуулах асуудлаар орос хятадын хилийн гаалийн зөвлөлгөөнд 2007 оны 10-р сарын 16-нд хятадын гаалийн ажилтнуудын үлдээсэн баримтаас үзэхэд хятадын талын хил дээр Харбины гаалийн бүсийн орчимд 2006-2007 онуудад бөхөнгийн 165 эвэр хураагджээ. Хятадын Шинжиан-Уйгарын автономит бүсийн (хятад –казахстаны болон хятад–киргизийн хил) гааль дээр хураагдсан хэмжээтэй харьцуулахад энэ нь харьцангуй бага хэмжээ юм. Урумчи хотын гаалийн удирдлагын хууль бус наймаатай тэмцэх тасгийнхан 1999-2007 оны хооронд бөхөнгийн 5386 кг эвэр хураажээ. Эдгээр онуудад хамгийн их нь 1793 кг эвэр хууль бусаар давуулсан бөгөөд (ойролцоогоор 4482 бодгаль) казахстантай хиллэдэг бүсэд 2001 оны 11-р сарын 26-нд саатуулжээ. Энэ ачааны нийт үнэ нь 269 сая юаньаар үнэлэгджээ.



Бөхөнгийн хураагдсан эвэрүүд (*Saiga tatarica tatarica*).
Зургийг Б.Бүүвэйбаатар



Байгаль орчимд хууль бусаар хил давуулах гээд саатуулагдсан бөхөнгийн эвэрүүд.

ОХУ-ын холбооны гаалийн албаны Сибирийн хэлтсийн Забайкальск-ийн гаалийнханы авсан зураг

Шинжиан-Уйгарын автономит улсын хил бөхөнгийн тархац нутагт илүү ойрхон бөгөөд 2000-аад оны эхэнд бөхөнгийн эврийн хууль бус хил давуулалтын урсгал илүү их байсан. Забайкаль болон Алс Дорнодод бөхөнгийн эврийг хууль бусаар хилээр авч гарах нь харьцангуй шинэхэн үзэгдэл болно. Өмнө нь тийм баримтууд илэрч байсангүй. Түүнээс гадна, хэрвээ казах-хятадын хилээр Казахстанд, магадгүй Узбекистанд агнасан эврүүдийг авч гардаг бол орос хятадын хилээр халимагийн популяцийн эврийг гаргах болно. Харамсалтай нь 4-р сард хураагдсан эвэрнүүдийн гарал үүсэл одоохондоо тодорхойгүй байна.

Халимагт бөхөнгийн хулгайн анчдыг шүүх хурал болов

Бөхөнгийн хулгайн ангийн хэд хэдэн тохиолдлууд Халимагийн шүүхийн янз бүрийн түвшинд байна. Хамгийн том нь ихээхэн хэмжээний хохирол учруулсан, хууль бус анд буруутгагдсан 26 настай Сергей Манджиевагийн хэрэг юм (п. "а" ч. 1 ст. 256 УК РФ). Халимагийн прокурорын байгууллагын хэвлэлийн албаны 2008 оны 10-р сарын 1-нд мэдээлснээр 2007 оны 10-р сард бөхөнгийн 3 шаргачинг буудсан байна. Черноземле-ийн мужийн шүүхээс буруутанд 6 сарын хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэж, цалингийнх нь 15 хувийг улсын орлого болгох шийдвэр гаргажээ. Мужийн прокурорийн заргаар хулгайн анчнаас улсын төсөвд 81 мянга 900 рублийн экологийн хохирлын хэмжээг албадан төлүүлжээ.

Халимаг улсын дотоод хэргийн яамны хэвлэлийн албаны мэдээгээр 2008 оны 9-р сарны 19-нд нийслэлийн цагдаагийн ажилтнууд бөхөнгийн мах зарж байсан 26 настай эмэгтэйг

Монголын гаалийн ажилтан 2008 оны 10-р сарын 20-нд вагоноор хятад руу бөхөнгийн 534 эврийг хууль бусаар гаргахаар оролдсон монголын 2 иргэнийг саатуулжээ. Биологийн хүрээлэнгийн шинжээчид бүх эврүүд нь *Saiga tatarica tatarica* зүйлд хамаарах ба монголын дэд зүйл биш, гаднаас авчирсан болохыг тодорхойлсон. Энэ баримтаар мөрдлөгө явагдаж байна. Энэ нь Хятад руу бөхөнгийн эврийг хууль бусаар давуулах гэсэн хоёрдох тохиолдол юм. Үүнээс өмнө 2006 онд Монголын хоёр иргэн 36 эвэртэй баригдсан байна.

Гаалийнхан бөхөнгийн эвэр лүү анхаарлаа хандуулдаггүй, наймаачид, хууль бус хил давуулагчдын сайн тогтсон сүлжээ байдаг бололтой. Энэ асуудлыг шийдэхийн тулд бид Монгол, Казахстан, Халимагийн зохих байгууллага, хүмүүсийн хооронд эврийн хууль бус хил давуулалт, хулгайн ангийн тохиолдлуудаар мэдээллийн солилцоог сайн болгох, гааль, шалгалтын ажилтнуудын сургалтыг зохион байгуулах шаардлагатай.

«Карасай батыр» заставийн хилчид (казах-киргизийн хил) Киргиз рүү автомашинаар явж байсан Казахстаны 2 иргэнийг саатуулсан байна. Саатуулагдсан хүмүүсийн машинд ойролцоогоор 300 кг жин бүхий бөхөнгийн эвэр-хууль бус ачааг хилчид илрүүлжээ. Мөрдлөгө явагдаж байгаа.

Монголын талаас нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл:

Б.Бүүвэйбаатар buuveibaatar@biology.mas.ac.mn болон

Б. Чимэддорж chimeddorj@wwf.mn,

Казахстаны талаас Казинформ веб сайтнаас үзээрэй:
<http://www.inform.kz/showarticle.php?lang=rus&id=218977>

саатуулжээ. Хээрийн амьтны мах гулуузыг гэгээн цагаан өдрөөр таксины зогсоол дээр “Газель” маркийн машины гэвшин дээрээс задгай борлуулж байжээ. Чиргүүл дээр нийтдээ 12 бөхөнг илрүүлсэн байна. Бөхөнгийн махыг тэр эмэгтэй Яшкуль-Элигийн зам дээр танихгүй хүнээс 1 ширхэгийг 1000 рублээр худалдаж авсан гэж ярьж байв. Энэ яриа хэр үнэн болохыг мөрдөн байцаалтаар тогтооно.

Халимаг улсын Яшкуль районд Утта суурингаас урагш 2008 оны 10-р сард мотоциклоор бөхөн агнасан 20 настай иргэнийг баривчилсан. Шүүхийн шийдвэрээр хэрэгтэнд 2500 рублийн торгууль ноогдуулсан. Одоогоор районы прокуратур хэрэгтэнгээс учруулсан хохирлыг нь улсад төлүүлэхээр материалыг нь бэлтгэж байна.

Халимагийн Черные Земли нутагт 2008 оны 11-р сарын 2-нд цагдаагийн ажилтнууд агнасан бөхөнгөө машиндаа авч явсан хоёр хулгайн анчинг саатуулжээ. Хэрэг зөрчигчид бөхөнгийн сүргийг дагаж явсаар 4 бөхөнг буудсан байна. Хүрээлэн буй орчинд учруулсан хохирол нь 100.000 рублээс дээш гарсан байна. Энэхүү районы прокурор Арслан Мухлаевын мэдээлсэнээр тэр өдөрт нь сэжигтэнгүүдэд хэргийнх нь шинж тэмдэгүүдээр ОХУ-ын эрүүгийн хуулийн 258 зүйлийн 2-т зааснаар (хууль бус агнуур) эрүүгийн хэрэг үүсгэсэн байна.

Устюрт дахь хулгайн ангийн тохиолдлууд

Узбекистаны хилээс холгүй (Матей элсний орчим) 10-р сарын сүүлчээр агнуур амьтан үйлдвэрлэлийн байцаагчид нисдэг тэргээр шалгалт хийж явахдаа Казахстаны хилийг хууль бусаар зөрчсөн Узбекистаны иргэнийг саатуулжээ. Хоёр хоногийн дотор 6 мотоцикл (10 хүн) саатуулагдсанаас 4-т нь зорчигчид үхсэн бөхөнгийн эвэр харин үлдсэн 2 нь (Урал мотоцикл) зэвсэглэсэн тус бүр хоёр хүнтэй баг бөхөн агнаж байлаа. Саатуулагдсан хүмүүс нэг бөхөн агнаж идсэн хэмээн хүлээн зөвшөөрчээ. Баримтаар хэрэг үүсгээгүй бөгөөд нотолгоо хангалтгүй байсан. Хулгайн анчдыг Челкарскийн районы дотоод хэргийн хэлтэст өгч, мотоциклийг нь хураан, хил зөрчсөн хэргээр торгож Узбекистан руу хүргүүлсэн байна.

Бетнакдальд хулгайн анчид саатуулагджээ

Алтын Дала байгаль хамгаалах санаачлага (ADCI) төслийн 4 байцаагчид байгаль хамгаалах болон мал эмнэлгийн цагдаагийн ажилтантай хамтарч 2009 оны 1-р сарын 19 нд Аркалыкаас Джекказган орох зам дээр Казахстандаа томоохонд орох зэс олборлох компанийн Камаз машиныг зогсоожээ. Ачааны тэвшин дээр нь тэд 9 бөхөнгийн толгой, арьс, махыг илрүүлсэн байна. Тэдгээрийн хоёр нь бие гүйцсэн, 3 нь залуухан оонууд, 4- нь шаргачин байв. Түүнчлэн Ямаха загварын 2 цасан дээр явагч, сум бүхий 4 буу илэрсэн. Тал нутаг цасаар бүрхэгдсэн өвлийн улиралд бөхөнгүүд хурдан шилжин хөдөлж чадахгүй, тэжээлийн дутагдлаас болж сульдсан байдаг. Энэ нь тэднийг цасан дээр явагчаас агнахад амархан объект болгож, цасан дээр явагчыг чоно агнахад ч ихээхэн ашигладаг. ADCI –ийн байцаагчид цасан дээр явагч ачсан машин тал нутаг руу чиглэж байгаа тухай мэдээлэл авчээ. Мэдээллийн дагуу байцаагчид болон цагдаа нар заасан чиглэлээс яваа машинуудыг зогсоон шалгасан байна.



ADCI-ийн байгаль хамгаалагч хууль бусаар агнагдсан бөхөнгийн хамт.

Зургийг Оркен Шажмуханбетов, АСБК/ADCI

REGNUM-ийн материалаар www.regnum.ru/news/1078098.html, www.regnum.ru/news/1079464.html (Черноземельский районд), [Элистагийн мэдээллийн сайтаас](http://www.elista.org/elista/index.php) .ORG, <http://www.elista.org/elista/index.php> (Яшкуль районд) ба «Известия Калмыкии», <http://www.elista.org/elista/files/ik/240908/3.pdf> (мах худалдаалсан тохиолдлууд)-ын мэдээллийг үзнэ үү.

Ангийн байцаагчдын үгээр, Узбекистанаас Казахстан чиглэлд мотоциклоор гаргасан маш сайн зам мөрүүд байдаг байна.

Узбекистаны байгаль орчны улсын хорооны шинэхэн байгуулагдсан САИ (Мэргэжлийн Амударийн шалгалт) –гийн байцаагчид 2008 оны 9-р сард Тахтакупир районы Кондарья горлын салаануудад бие гүйцсэн бөхөн, гахай, гургуул зэргийг хууль бусаар агнасан Тахиаташ хотын 2 иргэнийг саатуулжээ. Эрүүгийн хэрэг үүсгэн Нукуск хотын шүүхийн шийдвэрээр хулгайн анчид учруулсан хохиролоо ойролцоогоор 2800 \$ хэмжээгээр нөхөн төлжээ.



Камаз машинаас илэрсэн бөхөнгийн толгойнууд. Зургийг Оркен Шажмуханбетов, АСБК/ADCI

Бүх зорчигчид уулын баяжуулах компани болон түүний салбарын ажилчид бөгөөд тэдний хоёр нь нөлөө бүхий топ менежерүүд байв. Түүнчлэн тэдний холбоотнууд болох хүмүүс хоёр илүү ганган машинтай байсан ба тэдний нэрийг зарлана гэдэг юу л бол доо. Машинд нь буу сум байгаа хэдий ч, хулгайн анчид хулгайн аргаар агнасан амьтдыг нутгийн малчнаас авсан хэмээн хэлжээ. Энэ саатуулалтаар бөхөнгийн хууль бус агнуур зөвхөн нутгийн иргэд орлого олохын тулд агнах төдийгүй, бас нөлөө бүхий хүмүүсийн хувьд спорт зугаа болж байгааг харуулж байна.

Түүнчлэн 2008 оны 9-р сард ADCI , ангийн аж ахуй, Ан амьтан үйлдвэрлэлийн байцаагчдын нэгдсэн хүчний ачаар Джекказганын ойролцоо хоёр бөхөнгийн шаргачин агнасан 2 хулгайн анчныг саатуулан барьжээ.

Шүүхийн шалгалтын дүнгээс хамаарч хулгайн анчдад 5000-7000\$ торгууль нүүрлэх эсвэл 2-5 жил хүртэл шоронд суулгах, мөн агнасан амьтан нэг бүрт 1000-2000 хүртлэх долларын нөхөн төлбөр оногдох болтой.



Эрдэм шинжилгээний өгүүллэгүүд

Бөхөнгийн янзага барих тэмдэглэх

Дж. К. Янг^{1,2}, Б.Бүүвэйбаатар³, А.Е. Файн⁴, Б.Лхагвасүрэн³, Дж.Бергер^{1,2}

¹Хээрийн суурин Northern Rockies, Зэрлэг амьтан хамгаалах сан (WCS), Монтанагийн их сургууль, Миссуола, Монтана, США;

²Биологийн факультет, Монтанагийн их сургууль, Миссуола, Монтана, США; ³Хөхтний экологийн лаборатори, Биологийн хүрээлэн, ШУА, Улаанбаатар, Монгол; ⁴Монголын хөтөлбөр WCS, Улаанбаатар, Монгол.

Монгол бөхөн ХХ зууны төгсгөлд тоон бууралтанд хүчтэй нэрвэгдсэн боловч үлдэж хоцорсон популяци нь төлөрхөг чанар, бэлгийн эрт боловсролт, байнгын ихэрлэлт зэргийнхээ ачаар сэргэх чадвартай байна. Популяцийн динамикт нөлөөлөгч үзүүлэлтүүдэд бие гүйцсэн бодгалиудын мэнд үлдэлт, янзаганы төрөлт хамаарах боловч эдгээр чухал динамик үзүүлэлтээр монгол бөхөнгийн дэд зүйлд мэдээлэл алга. Иймээс зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS), Монголын шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лабораторитой хамтран янзаганы нөхөн төлжилт, мэнд үлдэлтийг судлах төслийг санаачилсан юм. Төслийн зорилгуудад: 1) үржлийн өмнөх болон дараах үеийн бөхөнгийн тархацыг судлах, 2) янзаглах газруудыг тодорхойлох; 3) янзаглах цаг хугацаа, ихэрлэлтийн хувь, морфологийн шинж тэмдэгүүдийг монгол бөхөнгийн түүхэн мэдээллүүдтэй харьцуулах; 4) шинэ төрсөн бодгалиудын мэнд үлдэлтийн түвшинг судлах зэрэг байв. Хээрийн судалгааг Баруун Монголын Говь-Алтайн мужийн Шаргын хамгаалалтай газарт 2008 оны 5-р сарын 17-ноос 6-р сарын 21 ны хооронд явуулав. Мониторинг үргэлжилж байгаа болохоор бид янзаганы барилт, үхэл хорогдолтой холбоотой урьдчилсан мэдээнүүдийг орууллаа.



Дохиолол зүүсэн янзага.
Зургийг Ж.К.Яан/WCS



ШУА ба WCS хамтран монгол бөхөнд дохиоллын хүзүүвч зүүж байна.
Шаргын байгалийн нөөц газар, Говь-Алтай, Монгол улс.
Зургийг Ж.К.Яан/WCS

Өмнөх судалгаануудаас үзэхэд төрөх үеэрээ шаргачингууд сүрэг үүсгэх боловч өнөө цагт Монгол дахь тэдний нягтшил бүхэлдээ багасчээ. Магадгүй орон зайн тархалтын өөр хэлбэр оршиж байж болно. WCS болон ШУА-ийн эрдэмтэд анхлан хөхүүл шаргачин ба янзаганы бөөгнөрдөг газруудыг тодорхойлох зорилготой бөхөнгийн шаргачинг илрүүлэн олж ажиглалт хийлээ. Ажиглалтыг өдрийн цагаар 700 м –ээс багагүй зайд яндан дурангаар гүйцэтгэсэн. Бөхөнгийн шаргачинг хармагцаа 2-4 хүний баг янзагыг нь барихаар энэ газар луу дөхөж очсон. Барьсаны дараагаар эх нь янзагаа голохгүй байх үүднээс сэргийлэх арга хэмжээнүүдийг авсан (жишээ нь, бээлий өмсөх, норсон янзагануудыг барихгүй байх). Барьсан янзагануудын жинг авч хэмжин, радио дохиололтой хүзүүвч VHF (зураг үзнэ үү) зүүсэн. Радио хүзүүвчнүүд нь уян хатан оосортой бөгөөд янзага томрох тусам сунасаар өөрөө унадаг. Ажиглалтын 17 өдрийн дараа 6 өдрийн турш (2008 оны 6-р сарын 12-19) 40 дөнгөж төрсөн янзага барьсан. Түүнээс гадна энэ хугацаанд хүзүүвч зүүгээгүй 6 амьд, 3 үхсэн янзага олсон. Баригдсан 40 янзаганаас 22 нь эр бөгөөд ($2,80 \pm 0,32$ кг) жинтэй эм янзаганаасаа ($2,60 \pm 0,38$ кг, $t = 2,02$, $p = 0,05$) илүү байсан. 11 янзага ганцаар байсан нь шаргачингийн 58 хувь нь ихэрлэсэн тухай өгүүлж байна. Баригдсан ихрүүдийн 4 нь эр бодгалиуд, 4 нь эм бодгалиуд, 7 нь янз бүрийн хүйстэй байв.

Өнөөдрийн байдлаар хүзүүвчтэй янзагануудын 33 нь амьд байгаа харин 7 нь махчдын нөлөөнөөс болж үрэгдсэн байна. Нэгийг нь үнэг барьсан ба 3-ыг нь махчин шувууд хөнөөжээ. Мониторинг судалгаа үргэлжилж буй бөгөөд 7 хоног бүрийн 3 өдөрт нь янзага бүрийн байршлыг тодорхойлж байна. Эдгээр урьдчилсан үр дүнгүүд бөхөнгийн янзаганы үхэл хорогдлын шалтгаан, популяцийн демографикт нөлөөлөгч хүчин зүйлсүүдийг тодорхойлох олон жилийн төслийн эхний шатууд юм.

Монголд бөхөн хамгаалах төслийн хүрээнд мэдээллийн тогтолцоог сайжруулах шаардлагын үнэлгээ

Б.Чимэддорж

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, chimeddorj@wwf.mn

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас 2008 онд бөхөн тархсан нутгийн хүрээнд бөхөн түүний хамгааллын тухай нутгийн иргэдийн мэдээллийг дээшлүүлэх, зүйлийг хамгаалах зөв чиглэлд шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлох зорилготойгоор социологийн судалгааг явуулсан. Монгол бөхөнгийн тухай мэдлэгийн

одоогийн түвшинг үнэлэх ажлыг зорилтоо болгосон. Судалгааг 3 түвшинд явуулсан: бөхөн тархсан нутгийн иргэдийн дунд, байгаль хамгаалагч болон цагдаа нарын дунд, байгаль хамгаалах төрийн бодлогыг хариуцсан зохих тушаалын хүмүүсийн дунд. Судалгаанд 627 хүн оролцов.



Судлаачдын баг болон социологийн асуулгад оролцогчид.

Зургийг Б.Чимэддорж

1. Бөхөн хамгаалал ба орон нутгийн нөхөрлөлийн харьцаа

Асуулгад оролцогчдын хариултаас үзэхэд бөхөнгийн дэлхэц нутаг сүүлийн үед харьцангуй тогтвортой боловч гэрийн малтай бэлчээр давхацсаны улмаас зүйлийн тархац өөрчлөгдсөн. Энэ нь дараах шалтгаануудаас бий болсон:

- Сүүлийн жилүүдэд гэрийн малын тоо эрс нэмэгдсэн, үүний улмаас алслагдсан өмнө нь ашиглагдаггүй байсан нутгуудад мал бэлчих болсон.
- Бөхөнгийн тоо нэмэгдэж, түүний орших нутгийн хэмжээ өргөсөж гэрийн малын бэлчээрт орох болсон. Бэлчээрт бөхөн ирэх болсноор малчид дургүйцэн түүнийг үргээх, амьдрах нутгаас нь шахах болсон.

Гэрийн малаас бөхөнгийн орших дэлхэц нутгийг боломжийнхоо хэрээр чөлөөлөх нь чухал.

Хэрвээ энэ боломжгүй бол бөхөнгийн тархац нутагт малыг улирлаар сэлгэн бэлчээх практикыг нэвтрүүлэх хэрэгтэй. Усан хангамж дутагдалтай учраас мал байнга бэлчдэггүй газруудыг бөхөн ашиглаж болох юм. Гэрийн мал бэлчдэггүй боловч бөхөнгийн хувьд чухал нутгуудад (жишээ нь Шар Бөөрөг и Улаан Эргийн Нуруу) задгай ус байх ёстой. Бөхөнгийн ороо хөөцөөн болон төллөлт явагддаг чухал газруудыг илрүүлэх, хамгаалах шаардлагатай.

2. Хууль бус агнуур болон бөхөнгийн популяцийн өнөөгийн төлөв

Сүүлийн жилүүдэд явагдсан судалгаагаар бөхөнгийн хулгайн ангийн хэмжээ багассан байна. Бөхөнгийн дэлхэц нутгийн хэмжээ томорч, харин тоо толгой нэмэгдсэн ч үнэн хэрэгтээ хууль бус ан бүрэн тасарсангүй.



*Монгол бөхөн
Зургийг Б.Чимэддорж*



Иймээс бөхөнгийн амьдрах чухал нутгуудад бөхөнгийн хамгааллыг хариуцсан байгаль хамгаалагчидтай байх хэрэгтэй. Түүнээс гадна зарим нутгуудад түр хугацаагаар нутгийн иргэдээс олон нийтийн байцаагчдыг ажиллуулж болох юм. Энэ тохиолдолд тэдэнд бүрэн эрх олгох тухай нутгийн захиргаатай хэлэлцэх шаардлагатай.

Асуулгын хариултуудаас үзэхэд бөхөн агнах үндсэн суурь нь нутгийн иргэдийн ядуу байдал юм. Тиймээс тэдний амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Жишээлэхэд, сургалт явуулах, байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, ногоо тарих, гэр бүлийнхээ санхүүг удирдах талаар мэдээлэх, малын гаралтай түүхий эдээр гар урлалын эд зүйлсийг бэлтгэх сургалт явуулах, урамшуулал, зээлээр хангах гэх мэт.

3. Мэдээллийн хүрэлцээг сайжруулах

Нутгийн иргэдийн дунд бөхөнгийн тухай мэдээллийн ажлууд явагдаагүй байсан.

Байгаль хамгааллын хамтын үйл ажиллагааг дэмжин идэвхжүүлэх шаардлагатай, харин нутгийн иргэдийн дунд зохих мэдээллийг хүргэх хэрэгтэй. Түүнээс гадна телевиз, радиогийн тусгай нэвтрүүлгүүдийг явуулах, мэдээллийн хүрэлцээг сайжруулах, нутгийн хүүхдүүдэд бөхөнгийн хамгааллын тухай сургалт явуулах хэрэгтэй байна.

Төрийн ажилчид, гаалийнханыг бөхөнгийн тухай тодорхой ойлголт, мэдээллээр хангах шаардлагатай. Түүнээс гадна, зохих байгууллага болон хүмүүсийн хооронд хоёр талын мэдээллийн солилцоог хэвшүүлэх нь чухал. Энэ нь зүйлийг хамгаалах хүчин зүтгэлийг илүү сайжруулах үр дүнтэй хандлагуудын нэг болох юм.

Бөхөнгийн судалгаа явагдсан нутаг бол хэд хэдэн хүн ам суурьшсан сум суурин бүхий хөдөө аж ахуйн бүс болно. Үүнийг бөхөн хамгаалах үйл ажиллагааг явуулахдаа тусгах хэрэгтэй.

Байгаль хамгаалагч нарын оролцоотой баруун хойд Прикаспийн бөхөнгийн популяцийн мониторинг

Х. О'Нилл¹, Х.Манджиев², Э.Дж. Милнер-Гулланд¹

Лондонгийн эзэн хааны коллеж, “Черные земли” шим мандлын дархан газар helen.oneill07@imperial.ac.uk


ОХУ-ын Халимагийн бүгд найрамдах улсад Баруун хойд Прикаспийн бөхөнгийн популяцийн мониторингийг байгаль хамгаалагчдын хүчээр гүйцэтгэлээ. Өнөө цагт байгаль хамгаалагчид хяналт шалгалтын үедээ бөхөнг бүрэн гүйцэд бус ажиглалтаар гүйцэтгэж байна. Эргүүл хяналтын үед ажиглалт хийсэн байршил, цаг хугацааны тухай байцаагчдын тэмдэглэл хадгалагддаггүй болохоор эдгээр мэдээллийн үнэмшил хязгаарлагдмал; иймээс тооллого хийсэн нутгийн хамрах хүрээ, түвшинг үнэлэх боломжгүй. Популяцийн төлөвийн тухай үнэмшилтэй дүгнэлтүүдийг гаргахын тулд хугацааны туршид ажиглалтын үр дүнд засвар оруулахын тулд хийгдсэн ажиглалтуудын онцлогыг үнэлэх хэрэгтэй.

Байгаль хамгаалагчдын хүчээр хийж буй мониторингийн хөтөлбөрийн давуу тал нь бөхөн орших нутгуудынхаа талаарх мэдлэг, бөхөн ажигласан олон жилийн дадал туршлага байгаль хамгаалагчдад байгаа явдал юм. Зүйлийн ирээдүйн мэнд үлдэх стратегийн салшгүй нэгэн хэсэг болсон хүмүүсийн зүгээс дэмжлэг авна гэдэг гайхалтай. Энэ төслийн зорилго одоо хэрэгжиж буй байгаль хамгаалагчдын оролцоотой мониторингд цуглуулж буй мэдээллийн чанарыг сайжруулахын тулд зарим жижиг өөрчлөлтийг оруулахад оршино.

Энэ зорилгодоо хүрэхийн тулд Черные земли шим мандлын дархан газар болон Степной байгалийн нөөц газрын ГМС зургийг боловсруулсан байна. Үүний дүнд 2003 оны 9-р сараас 2007 оны 2-р сар хүртэл явагдсан ажиглалтуудын үндсэн дээр бөхөнгийн тархацын орон зайн дүн шинжилгээг хийх боломжыг олгосон төдийгүй одоогийн систем дэхь хазайлтыг тодорхойлоход ч ашиглаж болох болсон.

Түүнчлэн байгаль хамгаалагчдын хийсэн бөхөнгийн сүргийн хэмжээг үнэлэх нарийвчлалын судалгааг хийсэн. Үүний тулд бөхөнгийн сүргийн оронд хонины сүрэг болон байгаль хамгаалагчдын гүйцэтгэсэн тооллогын үед авсан бөхөнгийн сүргийн фото зургууд дээр туршилтыг явуулсан. Ийм байдлаар бөхөнгийн бодит тооны нарийн үнэлгээг хийж дараагаар нь түүнийгээ байгаль хамгаалагчдын дүнтэй харьцуулах байдлаар хийж болно. Бөхөнгийн тоо болон тооллогын маршрутын байрших маршрутын хооронд тодорхой харилцан хамаарал гарсан байна (зур.1).

Тооллогын маршрутын дагуу ихэнх мэдээлэл цугларсан болохоор бөхөнгийн тархацын тухай мэдээллийн жигд бус байдлын үндсэн тайлбар энэ юм гэж таамаглаж байна.



Хамарсан нутаг дэвсгэрийн талбайн үнэлгээ явагддаггүй болохоор тухайн нутагт үнэхээр бөхөнгийн нягтшил өндөр байна уу, эсвэл энд бусад газруудыг бодвол хамгийн их ажиглалт хийсэн болохоор бодгалиудын тааралдах магадлал нэмэгдэж, үүнтэй бөхөнгийн тохиолдоцын их тоо холбоотой юу гэдгийг тодорхойлох боломжгүй.


Байгаль хамгаалагчидын бөхөнгийн сүргийг тоолох нарийвчлал сайн байв (зураг 2). Черные земли шим мандлын дархан газрын байгаль хамгаалагчдын үнэлгээ болон фото зурган дээр харуулсан бөхөнгийн тооны хоорондох ялгаа дунджаар 20.07% SE = 9,184), Степной нөөц газрын байгаль хамгаалагчдын хувьд энэ үзүүлэлт 25.22 % (SE = 9,364) байв. Энэ нь 30 %-ийг үзүүлсэн бусад судалгаатай сайн таарч байв. Энэ шалгасан үнэлгээг цуглуулсан мэдээллээ боловсруулахдаа тооцож байж болно.

Хонин сүрэг дээр хийсэн тооллогын туршилт бөхөнгийн тооллогын үед авсан үр дүнгүүдтэй таарч байсан ба байгаль хамгаалагчид багахан тоотой байхад хэтрүүлж үнэлж байв (зураг 3). Бага тоотой туршилтан дээр сүрэг дэх хар зүсмийн хонинуудыг сүрэг дэхь бөхөнгийн эр гэж жишээ болгон тоолоход хар хонинуудыг хэтрүүлж тоолж байсан. Бага тоотой байхад хэтрүүлж тоолж байсан ч гэсэн хонинуудын нийт тоог гаргахдаа эсрэгээр дутуу тоолж байв.


Хэрвээ бөхөнгийн тооллогын үед ингэж явагддаг бол популяцийн тогтвортой байдлын түлхүүр хүчин зүйл болох эр оонын хувийг хэтрүүлж тоолсноор популяцийн статусын тухай алдаатай дүгнэлтэд хүргэж ч болох учраас ихээхэн анхаарах нь зүйтэй.



Мониторингийн хөтөлбөрт оролцож байгаа Черные земли дархан газрын байгаль хамгаалагчид. Зургийг Х.О'Нилл



Зураг 2.
Черные земли шим мандлын дархан газрын (а), Степной нөөц газрын байгаль хамгаалагчдын (б) үнэлгээгээр сүрэгдэх бөхөнгийн тоо г фото зураг дээрх тоотой харьцуулсан нь.



Зураг 3.
Степной нөөц газрын байгаль хамгаалагчдын хонин сүрэг дээр хийсэн тооллогын туршилт. (а) Хаяглан тоолохгүйгээр гаргасан бодит тоо толгой, (б) хаяглан тоолж гаргасан бодит тоо толгой.



Байгаль хамгаалагчид бөхөнгийн томоохон сүргийг тоолсон хэдхэн тохиолдол байгаа болохоор тэд нийт тоог хэтрүүлсэн үү үгүй юу гэдэг тодорхой бус байгаа. Хэрвээ сүрэг дэх бодгалиудын нийт тоог, эрэгчингүүдийн адилаар хэтрүүлж тоолсон бол эрэгчингүүдийг хэтрүүлсэн тооны нөлөө бага болж эдгээр хоёр үзүүлэлтүүд бие биенийгээ аль нэг хэмжээгээр тэгшитгэдэг. Төслийн үр дүнд хэд хэдэн зөвлөмж гарсан, жишээлэхэд байгаль хамгаалагчид хаана, хэзээ бөхөн бүртгэсэн, нутаг дэвсгэртээ хяналтын шалгалтын үедээ бөхөн хараагүй өдрүүдээ ч оруулж тэмдэглэж эхлэх ёстой. Энэ нь тархац, ажиглалтын магадлал, норм, популяцийн бүрэн үнэлгээг хийхэд мониторингийн бүх төлөвлөлтийн чухал хандлагуудыг бүртгэхэд маш чухал юм. Түүнээс гадна мэдээлэлд дүн шинжилгээ хийх үедээ байгаль хамгаалагчдын үнэлгээг шалгаж байх ёстой бөгөөд энэ нь популяцийн үнэлгээг илүү нарийвчлалтай хийх боломжтой болгоно.

Черные земли дархан газар болон Степной нөөц газруудын байгаль хамгаалагчдын хийсэн ажил бөхөн хамгаалахад маш чухал юм. Мониторинг хийхэд тэдний оролцоо маш амжилттай байсан бөгөөд бид энэ ажлаа үргэлжлүүлэхийг зөвлөж байна. Энэ төслөөр илүү нарийвчлалтай мэдээлэл авах болон төлөвлөлтөө сайжруулах замыг үзүүлсэн. Хөтөлбөрийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахын тулд хамгийн бага хөдөлмөрийн хүчээр ажлаа хийх байхаа гэж найдаж байна. Энэ төслийг Халимагийн их сургууль болон Лондонгийн эзэн



Хелен О'Нилл, Хонгур Манджиев дархан газарт.

хааны коллеж, BRIDGE хөтөлбөрийн Британийн зөвлөлийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хамтран гүйцэтгэлээ. Эргүүл шалгалтын олон жилийн мэдээллийг ИНТАС болон Дарвины санаачлага төслүүдийн санхүүжилтын үед цуглуулсан.

Халимагт хийсэн хамтын мониторингийн чадавхийн үнэлгээ

Элизабет Уайтбред¹, Диана Обгенова², Э.Дж.Милнер-Гулланд¹

¹ Лондонгийн эзэн хааны коллеж, ² Халимагийн улсын их сургууль, elisabeth.whitebread07@imperial.ac.uk

Хамтын мониторинг-нутгийн иргэд хамгааллын талаасаа сонирхол татсан зүйлийн экологийн тухай мэдээллийг цуглуулдаг арга юм. Энэ арга дэлхий дээр түгээмэл (www.monitoringmatters.org харна уу). Бид байгаль хамгаалагчдын оролцоотой мониторингийн хөтөлбөр аль хэдийн хэрэгжиж байгаа, нутгийн иргэдийг татах талаар сайтар ажил хийгдсэн Халимагт энэ арга үр дүнтэй байх нь уу гэдгийг харах зорилго тавьсан.

Бид бөхөнгийн дэлхэц нутгийн хүрээнд байрласан таван сууринд хамтын мониторингийн талаар богинохон хагас жилийн төсөл хэрэгжүүлсэн. Суурин болгонд бөхөнгийн ажиглалтыг явуулахад 5 фермерийн аж ахуйтаныг сонгосон. Эдгээр фермерүүд ихэнх цагаа суурингын гадна өнгөрүүлж, тэндээ амьдардаг, бөхөн байнга хардаг учраас сонгосон. Түүнээс гадна, малчид учраас амьтадын томоохон сүргийг тоолох туршлагатай юм.

Бид багаж хэрэгслээр (дуран, тоологч, луужин, үзэг, тэмдэглэлийн дэвтэр) хангахаар 6-р сарын дунд үеэс эхлэн фермер болгоныхоор явсан.



Төслийн баг нутгийн ажиглагчид бөхөнгийн тэмдэглэлийг хөтлөх заварчилгаа өгч байна. Зургийг Элизабет Уайтбред

Тэдэнд ажиглалтын цаг, мэдээллээ харсан цэг, сүргийн хэмжээ, боломжоороо хүйс, янзаганы тоо, ажигласан зайг ямар байдлаар тэмдэглэх талаар заварчилгаа өгсөн байлаа. Бид ажиглагчдыг боломжийнхоо хэрээр бөхөнтэй тааралдсаныгаа тэмдэглэж байхыг, харин бөхөн хайж ихэнх цагаа үрэхгүй байхыг хүссэн. Гэхдээ, сар бүрийн 1 болон 15 нд ажиглагч бүр өөрийнхөө хэсэгтээ, томоохон нутагтай байсан ч гэсэн 2 цагаас ихгүй хугацаанд бөхөнг тусгайлан хайж тэмдэглэж байхыг хүссэн. Энэ нь тоолого явуулах нэг стандарт тогтоох, давхардсан тооноос зайлсхийх оролдлого хийхэд хэрэгтэй байлаа. Эдгээр өдрүүдэд ажиглагчдыг амьтан хараагүй байсан ч гэсэн бөхөн байхгүй байгааг тодорхойлохын тулд тэмдэглэлээ дэвтэртээ бичиж байхыг хүслээ.


Хэдэн долоо хоногийн дараа бид анхдагч мэдээллүүдийг цуглуулах, бүгд зөв хийгдсэн эсэхийг шалгах аргаар буцаж ирлээ. Ажиглагчид арга зүйн хувьд сэтгэл ханамжтай боловч зарим нэгэнд дэвтэрээ бөглөхдөө асуудал үүсч, зарим ойлгомжгүй зүйлүүд гарч иржээ. Түүнээс гадна, зарим ажиглагчид бидний анхны ирсэнээс хойш нэг ч бөхөн хараагүй байдал гарсан бөгөөд ажиглагчдын бараг 44 % нь бөхөн тэмдэглээгүй байв. Ажиглалтын хугацаа нэлээд богинохон (дунджаар 13 өдөр) байсантай холбоотой боловч ихэнх ажиглалтыг тусгай хамгаалалттай газрын ойролцоо нутаг дэвсгэр дээр хийсэн болохоор энэ нь бөхөн умар зүг нүүдэллэж эхлээгүй эсвэл нүүдэл нь өмнө бодож байснаас ч бага илэрч байж болно. Тусгай хамгаалалттай газрын гадна талд мониторинг хийх нь чухал болохыг харуулж байгаа бөгөөд одоогоор бид тархцын бусад хэсгүүдэд бөхөнгийн шилжилтийн талаар маш бага мэдээлэлтэй байна.

Хоёрдахь удаагаа эргэж очихдоо Черные земли шим мандлын дархан газарт бөхөнгийн тооллого хийхээс хэдэн долоо хоногийн өмнө авсан фотозургуудыг ашиглан бөхөн тоолох үедээ ажиглагч бүрийн тооллогын нарийвчлалыг мөн үнэллээ. Фотозургуудыг сүргийн янз бүрийн хэмжээ, зай, ландшафтын хэлбэрээр ялгаатай байхаар сонгож авсан байлаа. Зураг бүрийг 30 секунд үзүүлдэг зураг дээр хичнээн бөхөн байгааг үнэлэхийг ажиглагчаас хүслээ. Хяналтын мэдээлэлтэй ажиглагчдын нарийвчлалыг харьцуулахын тулд бид мөн хэд хэдэн байгаль хамгаалагчдыг тест хийн шалгалаа.

Ажиглагчдийн үнэлгээ нь байгаль хамгаалагчдынхтай ойролцоо байсан ба хоёр хэсгийн хүмүүс зураг болгон дээрх бөхөнгийн тоог сүргийн хэмжээг нэмэгдэх хэрээр хэтрүүлж тоолох хандлага харууллаа. Ажиглалт хийх үеийн байгалийн нөхцөл, амьтдын хөдөлгөөнийг тооцоогүй ашигласан арга зүйтэй алдаа холбоотой байж болох юм. Гэвч байгаль хамгаалагчид болон ажиглагчид бодит нөхцөлд ойролцоо нарийвчлалтай байх болно хэмээн таамаглаж болно. Хэрвээ хамтын мониторингийг бүлгийн гишүүд бүхэлдээ дэмжихгүй (түүнчлэн зарим ажиглагчид) бол төслийн ирээдүйд аюул учирна. Иймээс энэ арга зүйд суурингийн иргэдийн хандлагыг үнэллээ. Черные земли дархан газар болон Степной нөөц газарт явагдаж байгаа мониторингийн тухай цөөхөн хэдэн хүн мэдэж байхад ихэнх нь тусгай хамгаалалтай нутаг байгаа тухай мэдэж байлаа.



Бөхөнгийн залуу найз.
Зургийг Э.Уайтбрэд



Суурин болгоны ажиглагчдын ажиглалтийн мужийн зураг. Одоогоор ажиглалтанд тусгай хамгаалалтай нутгийнхаас 34 хувь илүү 61.500 га-аас илүү нутаг хамрагдсан. Энгийн болгохын тулд ажиглалтын бүх хэсгүүдийг дугуйгаар тэмдэглэлээ.

- Эрденевский
- Хулхутта
- Молодежный
- Таван-Гашун
- Утта

Хамтын мониторинг явуулах санааг үнэлэхээр асуухад асуултад оролцогчдын 66 хувь нь энэ сайн эсвэл бүр сайн санаа гэж хэлж байсан, түүнчлэн 96 хувь нь энэ аргыг дэмжих болно гэж хэлэхэд үлдсэн 4 хувь нь энэ санааны эсрэг итгэл муутай хэлж байв. Энэ бол гайхалтай эерэг үр дүн бөгөөд ирээдүйн төсөлд сайн сэдэл байсан.

Нэгдүгээр сард аргагүйг сайжруулах, засвар оруулах, мөн олон тооны ажиглагч эсвэл суурингуудыг татах боломжит замуудын талаар хэлэлцэх нийтийн уулзалтыг зохион байгуулна. Цаг хугацааны туршид бид бөхөнгийн тархацын прикаспийн хэсэгт бөхөн ажиглагч нарын сүлжээг байгуулна гэж найдаж байна.

Энэ төслийг Халимагийн их сургууль болон Лондонгийн эзэн хааны коллеж, BRIDGE хөтөлбөрийн Британийн зөвлөлийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хамтран гүйцэтгэлээ.

Узбекистан дахь үржлийнхээ хуучин нутаг руу бөхөн буцаж ирэх болов уу?

Быкова Е.А.¹, Есипов А.В.¹, Черногаев Е.А.²

¹Узбекистаны ШУА-ийн амьтан судлалын хүрээлэн, ²Тугайны төсөл ГЭФ/ПРООН, esipov@sarkor.uz

Өнгөрсөн хугацаанд Устюртийн тэгш өндөрлөгийн Узбекийн хэсэгт бөхөн олноороо төллөх нь энгийн үзэгдэл байсан тухай Фадеева (1975), Реймова, Карабекова (1980), Ишунина, (1987) нарын ажлуудад дурджээ. Гэвч одоо бол, агнуурын хүчтэй дарамт болон хил орчмын Устюртийн популяцийн нийт хэмжээ багассаны улмаас Узбекистанд бөхөнгийн төллөлт маш ховор үзэгдэл болжээ. Бөхөнгүүд голчлон энд улирлын нүүдлийнхээ үед Казахстаны ойролцоох мужуудаас өмнө зүгт өвөлжөө нутаг руу шилжихдээ ажиглагддаг. Узбекистанд 12-р сард мөн бөхөнгийн хөөцөөн явагддаг. Бөхөнгийн хамгийн бага тоо -1000 бодгаль 2008 онд Узбекистанд ажиглагдсан. Узбекийн Устюртийн хойд хэсэгт агаарын болон автомашины тооллого хийж байсан төллөх үеийн сүүлчийн албан ёсны баримтууд 1991 онд хамаарна (Уз. улсын биохиалтын тайлан).

Нийт 1096 янзага тоолсон байсан ба хамгийн их амьтдын бөөгнөрөл Чурук-Белеулы хэсэгт тэмдэглэгджээ. Бидний судалгаагаар 2003 оноос эхлэн бөхөнгийн үржил эсвэл бүр байхгүй (2003-2005 онуудад), эсвэл ганц нэг тохиолдлууд (2006-2007 онуудад) тэмдэглэгджээ. Сүүлийн жилүүдэд үржлийн үеийн бөхөнгийн хамгийн их тоо 2008 онд тэмдэглэсэн байлаа.

FFI-ийн дэмжлэгтэйгээр бидний явуулсан орон нутгийн иргэдээс асуулгын мэдээгээр 2008 онд төллөлт 4-р сарын 28-аас 5-р сарын 20-ны хооронд явагджээ. Жижигхэн тусгаарлагдсан 5-аас 15 бодгаль хүртэл хэмжээтэй, хамгийн ихдээ нэг сүрэгт 20 бодгальтай сүргүүд тэмдэглэсэн байлаа. Бүгд 180 шаргачин 52 янзага тэмдэглэсэн. Ганцаар ч байсан, мөн ихрүүд ч байв. Нэг эмэгчинд оногдох янзаганы тоо (0.28) шаргачингууд ихээр сувайрсаныг харуулж байна.



Одоогоор Узбекистан дахь бөхөнгийн үржлийн үндсэн нутгууд Алмамбет хөндий орчимд байх бөгөөд янзага төрсөн ганц нэг тохиолдлууд Каракалпакия суурингаас өмнө зүгт 30 км-т бас тэмдэглэгдсэн. Түүнээс гадна, Возрождение арал (А.Нуриджановын аман мэдээ) болон Арал тэнгисийн зүүн эргийн (М. Косбергенова-ийн өгүүллэг харна уу №7) тусгаарлагдсан сүргүүдэд үржил тэмдэглэгдсэн.

Хулгайн анчдын хувьд гэгээн зүйл гэж байхгүй бөгөөд үржлийнх нь үед зуун жилээр хориглох ч тэдэнд утга учиргүй. Бидэнд 2008 оны Жаслык болон Каракалпакия суурингуудад бөхөнгийн махны худалдааны тухай найдвартай мэдээллүүд байгаа бөгөөд Казахстан руу чиглэсэн галт тэргэнд бөхөнгийн махны үнэ 3 дахин өсч эрчимтэй худалдаа хийгддэг байна.


Бүр 1991 онд Каракалпакстанын Кунград районы нутагт байрлах Сайгачий нөөц газрыг бөхөнгийн үржлийн нутгуудыг хамгаалах зорилгоор байгуулж байсан. Гэвч энэ хамгаалагдсан нутаг үр дүнтэй байсангүй. Газар дээр нь тусгай хамгаалалттай нутгийн тэмдэглэгээ ч хийгдээгүй байсан (бид танигдахааргүй болсон ганцхан хилийн тэмдэг олсон). Ийм нөхцөлд албаны хүмүүс, нутгийн хүмүүс ч чухам хаана нь нөөц газар байрласан талаар төсөөлөл ч үгүй байв. Бодит байдалд хэн ч энэ нутаг дэвсгэрийн хамгаалыг анхаарсангүй. Сайгачий нөөц газрын түүх бол нөөц газруудыг байгуулсангүй харин зөвхөн энгийн саналаар зөвшөөрөгдсөн урьд цагийн тусгай хамгаалалтай газруудын үр дүн багатайг харуулсан жишээ болжээ. Үр дүнд нь Сайгачий нөөц газар бол хамгаалж байгаа зүйл нь бараг устчихсан ганц хамгаалалтай нутаг дэвсгэр болжээ. Нутаг дэвсгэрийн хэмжээ ч тус болсонгүй. Нөөц газар 1 сая га талбай эзлэх Узбекистаны хамгийн том тусгай хамгаалалтай нутаг дэвсгэр ажээ.

Дээр дурьдсантай холбоотойгоор Сайгачий нөөц газрыг дахин шинэчлэн байгуулах шаардлагатай байна. Энэхүү ажлыг тухайн газарт удирдах төлөвлөгөөг боловсруулах, хууль зүйн эрхийг нь түүнд олгох замаар хийж байж болно. Бөхөнгийн хувьд хамгийн тохиромжтой нутгуудыг хамгаалалтанд авахын тулд нөөц газрын хилийг хойд зүгтүү өргөтгөх шаардлагатай. Нутгийн иргэдийн сонирхолыг боогдуулахгүй байх үүднээс хатуу хамгаалалтай хэсэг, хязгаарлагдмал үйл ажиллагаатай

хэсгүүдийг ялган нутаг дэвсгэрийн бүсчлэлийг явуулах шаардлагатай. Мэргэжилтэнүүдийг оролцуулан биологийн төрөл зүйлд бүхэлдээ болон бөхөнд үзүүлэх үндсэн аюулуудыг тооцон, тухайлбал зохих удирдлагын шийдвэрүүдийг тэмдэглэсэн тусгай хамгаалалтай газрыг удирдах төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай. Төлөвлөгөөнд нутгийн иргэд болон удирдах байгууллагуудтай харилцах тодорхой хэлбэрийг тусгах ёстой.

Сэтгүүлийн өмнөх дугаарт (№7) бид 2008 оны 4-р сараас БХХ санаачилгаар Уз. ШУА-ийн амьтан судлалын хүрээлэн болон “FFI” хамтран ТХГН-ийн илүү хатуу хэлбэр лүү нөөц газрыг шинэчлэн зохион байгуулах үндэслэлийг бэлтгэх төслийг гүйцэтгэж байгааг мэдээлсэн билээ. “Disney Wildlife Foundation” болон “WildInvest”-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр төсөл явагдаж байна. Одоо бол санал болгож буй нөөц газрын хил хязгаарыг аль хэдийн тодорхойлсон (зураг). Түүний нутаг дэвсгэрийг Каракалпакскийн Кунград болон Муйнак районуудад байршуулсан. Нөөц газрын хатуу хамгаалалтанд авах талбайг 6 хэсэгт хувааж, 735200 га болгожээ. Орчны бүсийн талбай нь 345600 га. Нөөц газрын баруун болон хойд хил нь Казахстаны улсын хилтэй давхцдаг. Зүүн талдаа хил нь Арал тэнгисийн эргийн дагуу улсын хилээс урагш Акбулак булаг хүртэл үргэлжилнэ. Өмнөд хил нь Белеулын ханын нуранги, Чурук худаг, Жарынкудук хөндийгөөр үргэлжилнэ. Нөөц газрын санал болгож буй нутагт бөхөнгийн хувьд чухал газрууд бүрэн багтсан. Хориотой бүс-хуучин цэргийн полигон. Урьдын бөхөнгийн бөөнөөрөө төллөдөг газруудын ихэнх нь дурьдсан нутгийн хил дотор оршиж байгаа. Санал болгож байгаа нутаг нь суурин газраас нэлээд зайтай байрлаж, 4-р сараас 10-р сар хүртэл малын бэлчээрт бага зэрэг ашиглагддаг.

Цаасан дээр бичигдсэн ТХГН-ыг нутаг дэвсгэрийн хамгааллын бодьтой идэвхтэй механизм руу хувиргах замд эхний алхамаа хийх, Устюртийн тэгш өндөрлөгийн байгаль болон соёл түүхийн ховор комплекс болох бөхөн болон бусад төлөөлөгчдийг идэвхтэй хамгаалах зорилготойгоор Устюртэд хамгаалалтай нутаг дэвсгэрийн хил дамнан системийг байгуулах урьдчилсан нөхцлийг бид хийж чадна гэдэгт итгэж байна.



Зураг. Сайгачий төлөвлөж буй нөөц газрын хил, бүсчлэлүүд

- - хэсэг: I - Дуана, II – Жидейлы, III – Алмамбет, IV – Чурук, V – Белеулы, VI – Жарынкудук
- - орчны бүс

Казахстаны өмнө зүгт Арысск-Карактаускийн дархан газрын бүсэд бөхөнтэй (*Saiga tatarica tatarica*) тааралдсан тухай

Алтай Жатканбаев

Казахстаны амьтан судлалын хүрээлэн, wildlife@nursat.kz

Арысск-Карактаускийн дархан газрын бүсийн 404000 га нутаг дэвсгэр 2004 оны 9-р сард бид амьтны судалгааг явуулсан. Тухайн район нь Сырдарья голын баруун эргийн цөлийн хэсгүүдийг оруулсан Кызылкумын цөлийн казахстаны хэсэгт байрладаг. Бидний зорилго томоохон шувуу болон хөхтний зүйлүүдийг тоолоход оршиж байлаа. Автомашини маршрутын нийт урт нь ойролцоогоор 800 км байлаа. Маршрутууд бараг тэгшхэн заримдаг цөл болон намхан толгодуудтай элсэн дундуур ч гарсан байна. Судалгаа хийсэн нутагт цөлийн намхан ургамалжилт зонхилсон байв. Ийм нөхцөлд томоохон сэртэн амьтдыг тоолоход автомашины судалгаа илүү үр дүнтэй төдийгүй агаарын тооллоготой харьцуулахад харьцангуй хямдхан байсан.

Бидэнтэй нэлээн сайн тэвээргэтэй бөхөнгийн шаргачин тааралдсан нь бетпакдалинскийн популяцийн одоогоор хамгийн өмнөд цэгт тэмдэглэсэн бодгаль болж байна. Баиркум болон Аккум суурингуудаас баруун тийшэх район өмнө нь бөхөнгийн нутгийн сүргүүд байдаг нутаг гэж үздэг байсан. Талын туруутанууд 1980-аад оны хоёрдугаар хагаст аль нэг хэмжээгээр энэ районд жижиг сүргээр байнга ажиглагдсан, харин 2000-аад оны эхэнд хаврын улиралд энд зөвхөн 1-2

бодгалиуд тааралдсан байв. Сүүлдээ энд бөхөн дахиад тэмдэглэгдсэнгүй (Б. М. Губин, аман мэдээ). Энэ районд зөвлөлт засгийн үед заримдаг цөл хөдөө аж ахуйн хэрэгцээнд ашиглаж байсан, харин 2004 онд эдгээр хөдөө аж ахуйн эдэлбэрийн багахан хэсгийг ашигласан.

Тооллогын үед бид хар сүүлтийн (*Gazella subgutturosa*) 6 сүрэг 38 бодгаль тэмдэглэсэн. Тэдний ихэнх нь (4 сүрэг 24 бодгаль) хүчтэй артезианы цооногийн ойролцоо ажиглагдсан. Хар сүүлтийн олон тооны шинэхэн мөр, хорголууд тэд ус уухдаа энэ газрыг байнга ашигладагийг гэрчилж байна. Арысск-Карактаускийн дархан бүсийн олон газруудад даралтат цооногууд тууртан амьтдын байнга ус уух газар нь болдог.

Шардарийн тал дахь бөхөнгийн амьдрах нутаг нь Арысск-Карактаускийн дархан бүсийн нутаг дэвсгэрт бараг бүтнээрээ ордог. Бөхөн энд цөөхөн тоогоор тааралддаг ч гэсэн талын туруутаны төлөв байдлын мониторинг хамгаалалтай нутгийн хувьд урьтал болно. Энэ бүсэд бөхөн үргэлжлэн оршиж байгаа эсэхийг эцэслэн батлахын тулд зэрлэг туруутаны судалгааг яаралтай явуулах шаардлагатай.


Бөхөнгийн тоологдсон дулааны мэдрэмж бүхий агаараас авсан зургийг хэрэглэх нь

Черноок В.И

ГИПРОРЫБФЛОТ, chernook@grf.spb.ru, chernook@mail.ru

Экологийн судалгаа болон мониторинг явуулахад бөхөнгийн тооллого чухал байр суурьтай. Тооллого явуулахад ашиглаж болох аргуудын нэг бол бусад олон зэрлэг амьтад дээр амжилттай туршин хэрэглэж ирсэн агаараас зураг авах арга юм. Далайн хав, морж, цаа буга зэрэг амьтдыг тоолоход бид 1997 оноос эхлэн дулааны мэдрэмж бүхий агаарын зураг авалтыг амжилттай хэрэглэж байна. Бүлээн цуст эдгээр амьтад болон хүрээлэн буй орчны хоорондох дулааны зөрүүг 150-250м өндөрөөс дулааныг мэдрэгч багажийн тусламжтайгаар илрүүлэхэд хангалттай байдаг нөхцөл нь хэт улаан туяаны багажийг хэрэглэх боломж, үр дүнг бий болгосон. Дулааны мэдрэмж бүхий зураг авалт харагдац том талбайд (ойролцоогоор 400 м) өндөр нягтшилтайгаар хийгдэх учраас амьтдын тооллогыг ихээхэн үнэмшилтэй хийх боломжийг олгодог.

Дулааны-зургийн, видео дүрсүүдийг тоон хэлбэрээр бүртгэх нь тэдгээрийн компьютер боловсруулалт хийх, амьтдыг таних, илрүүлэх, тоолох автомат алгоритмыг бий болгох боломжуудыг олгодог.



Дулааны дүрслэлүүд



Далайн хавууд (улаанаар далайн хавын зулзагыг тэмдэглэв)

Зургийг В.Черноок

Агаараас авсан зургийн материалуудыг баримтжуулах нь амьтадын тооллогын нарийвчлалыг үнэлэх, хянах зэрэгт зургийн зарим хэсгүүдийг олон дахин харах боломжтой болгодог.

Микрофоны тусламжтай ажиглалтынхаа аман мэдээллийг компьютерт оруулсанаар өмнөх агаарын ажиглалт тооллогын үр дүнтэй харьцуулах боломж бий болдог. Компьютерт автоматаар солбицол, нислэгийн үзүүлэлтүүд (сансрын хиймэл дагуулын тусламжтайгаар), мөн нислэгийн өндөр ордог. Ингэж агаараас авсан зургаа газарзүйн координаттай холбосноор судалсан талбайнхаа хэмжээг нарийн гаргах боломжтой.

Амьтдын тоо хэмжээний тухай мэдээллийн үндсэн эх булаг бол дулааны дүрслэлүүд. Бөхөнгийн бөөгнөрсөн фотозураг болон видеодүрснүүд нь дулааны дүрслэлийг таних магадлалд итгэхэд үнэмжлийг олгоно. Үзүүлж байгаа зургууд дээр Цагаан тэнгис агаарын тооллогын үед далайн хавны дулааны дүрслэлүүд болон тэдгээрийн тоон зургуудыг харуулсан.



Ийм чанар бүхий дулааны дүрслэл болон зургуудыг бөхөнгийн агаарын зураг авалтын үеэр авах болно. Зурган дээрх бөхөн болон зохих хэсгийн дулааны дүрслэлүүдийг тоолох нь багажаар тоолох нарийвчлалыг үнэлэх боломжтой. Бөхөнгийн агаарын тооллогыг амьтдын зураг авалтыг багажын тусламжтай гүйцэтгэхэд зориулан тоногдсон Л-410 загварын онгоцоор гүйцэтгэж болно. Энэ жижигхэн чимээ багатай онгоц 200-240 км/цаг хурдтайгаар 7 цагийн нислэг гүйцэтгэдэг.

Зэрлэг амьтдын томоохон бөөгнөрөлыг харж тоолоход нарийн тоог гаргаж чаддаггүй. Харж тоолоход харах талбайн хязгаар их алдаатай гарах, мөн харж ажигласаны батлах баримт үлддэггүй. Иймээс багажны тусламжтай агаарын зураг авалт бол амьтдыг тоолох хамгийн нарийн арга болох бөгөөд гарч буй өөрчлөлтүүдэд дүн шинжилгээ хийх боломжтой болгодог. Үүнийг зөвхөн байнгын багаж ашигласан агаарын тооллогын үндсэн дээр хийх боломжтой.

“Яшкульский” үржүүлгийн газар дахь энергийн элдэв эх үүсвэрүүд

Вадим Санжеев

Халимагийн бүгд найрамдах улсын зэрлэг амьтдын төв, kalmsaiga@mail.ru

Халимагийн бүгд найрамдах улсад «Яшкульский» үржүүлгийн төвийг байгуулах, хөгжүүлэх, түүний ололт, бэрхшээлтэй талуудын тухай *Saiga News* сэтгүүлд нэг бус удаа бичигдсэн. Энэ мэдээлэлдээ бид хамгийн үндсэн бөгөөд үнэтэй үйлчилгээ болох цахилгаан энергийн үнийн байнгын өсөлт, хөрөнгө мөнгөний дутагдалтай нөхцөлд үржүүлгийн төв хэрхэн оршиж байгааг өгүүлэхийг хүссэн юм.

Халимагийн бүгд найрамдах улс бол нартай, салхитай өдрүүд ихтэй учраас нарны болон салхины энергийн гэх мэт бусад эх үүсвэрүүдийг ашиглахад тааламжтай боломжууд байдаг.

Үржүүлгийн газарт 5 жилийн өмнө салхины энергийг цахилгааны энерги болгон хувиргах 4 кВт-ийн хүчдэлтэй төхөөрөмж бий болсон. Гаргаж байгаа энерги нь төвийн ажилчдын байр, болон зочдын хэсгийн халаалт, гадаад гэрэлтүүлгэнд хүрч байлаа. Гэвч, “салхин тээрэмд” нэг дутагдалтай тал байсан нь аккумулятор байхгүй байлаа. Иймэрхүү үйлдвэрийн дутуу боловсруулалтаас үүдэн салхигүй өдрүүдэд төхөөрөмжөө ашиглаж боломжгүй байв.

2008 оны эхээр үржүүлгийн төв 2 нарны батерей олж авч байшингынхаа дээвэр дээр байрлуулсан. Энергээ аккумуляторт хуримтлуулж харин дараагаар нь цахилгаан хэрэгслүүдээ ажиллуулахад ашигладаг. Байгаа батерейнуудын чадал компьютер, хөргөгч, телевизор, гадаад гэрэлтүүлгийг ажиллуулахад хүрэлцээтэй.

Бүхэлдээ ийм төхөөрөмжүүд эвтэйхэн, хэмнэлттэй-цахилгаан энергийн төлбөрийн зарцуулалт нэлээд буурсан, харин нарны батерей авах зардлууд удахгүй бүрэн нөхөгдөх байх.



«Яшкульский» үржүүлгийн төв дэх нарны батерейнууд
Зургийг В. Санжеева

«Яшкульский» үржүүлгийн төв дэх «салхин тээрэм»
Зургийг Ю. Арылова

Редакцаас:

Нарны энерги ашиглалтыг дэмжигч Стивен Голд 2003 онд Сан-Франциско хотод зэрлэг амьтан хамгаалах сүлжээний (WCN) жил бүрийн үзэсгэлэнг сонирхсон. Энд түүнтэй Ребекку Клейн уулзаж Ботсванд судалгаа хийхийн тулд цахилгаан энерги хэрэгтэй болоод байгаагаа ярьсан байна. Өөрийн “нарны байшинг” зохион бүтээсэн Голд WCN-ийн захирал Чарльзом Ноузомд холбогдон, түүнд сайн дурын тусламжаа санал болгосон. Корпораци болон хувь хүмүүсээс өгөөмөр хандивыг авахын тулд 3 жил мятаршгүй зүтгэл, шинэ нарны батерей байрлуулах шаардлагатай жагсаалтаа гаргаснаас хойш Голд нарны батерей авахад зориулж ойролцоогоор 450000 доллар цуглуулсан.

Өнөөдрийн байдлаар 8 янз бүрийн систем тасралтгүйгээр Кени, Эфиопид ажиллаж байгаа, ахиж хоёрыг Ботсван ба Зимбабвед суурилуулсан. Төслийг ертөнцийн өөр хэсэгт бусад хүмүүст үргэлжлүүлэн дэлгэрүүлж байна. Энэ онд ЗАХС нарны батерейг суурилалтуудыг зохион байгуулахад хүндтэй түншээр БХХ-г тодорхойлсон.

Хэрвээ таны төсөл одоогоор БХХ-д нэгдээгүй байсанч, хэрвээ та бөхөнтэй холбоотой үйлсэд эсвэл бөхөн тархсан улсуудад

байгаль хамгааллын үйлсэд нарны батарей шаардлагатай байгаа бол та санхүүжилт авах эрхтэй! Хэрвээ таны төсөл нарны батарейгаарх ЗАХС –ны төслөөс ашиг авч чадна гэж үзэж байгаа бол mail@saiga-conservation.com хаягаар бүх шаардлагатай зүйлс (өдөр тутам хэрэглэх зүйлс төдийгүй нарны энергийг юунд ашиглаж болох бүх зүйлсийг оруулсан) жагсаалтыг явуулна уу.

Төслүүдийн тойм

Бөхөн хамгаалах альянсийн 2008 оны жижиг төслүүдийн хөтөлбөрийн ялагчид тодорлоо!



Бөхөн хамгаалах холбооны жижиг төслийн хөтөлбөрийн (ЖТХ) хоёрдугаар шат 2008 онд боллоо. Хөтөлбөр 2007 оноос явж байгаа бөгөөд SCA-ийн веб хуудас дээр тавигдсан гайхалтай үр дүнгүүдийг үзүүлсэн. ЖТХ-ийн зорилт бол байгаль дээр бөхөн хамгаалахад нэг жилийн 2000 долларийн төсөл авах хүсэлтээ өгсөн бөхөнгийн амьдрах нутагт ажилладаг хүмүүст боломж олгох юм. Төслүүд бөхөн хамгаалах дунд хугацааны ажлын хөтөлбөрийн гүйцэтгэлд хувь нэмрээ оруулах ёстой.

Энэ онд ЖТХ-ийн хүрээнд 5 орноос 18 хүсэлт хүлээж авсан. Хөтөлбөр дахин Зэрлэг амьтдыг хамгаалах сүлжээний (WCN) санхүүгийн дэмжлэгтэйгээр явагдсан. SCA-ийн удирдлагууд өөрийнхөө жил бүрийн хурлаар Алматад хүсэлтүүдийг авч үзэн энэ жилийн уралдааны ялагчид болсон хүмүүсийг зарлахад таатай байна:

1. Александр Грачев (Казахстан), Бөхөнгийн Уралын популяцийн үржлийн онцлог, популяцийн бүтцийг судлах эрдэм шинжилгээний төслийг гүйцэтгэнэ. Одоогоор энэ популяцийн төлөвийн тухай мэдээлэл бага учраас энэ ажил маш чухал юм.

2. Максет Косбергенов (Узбекистан). Узбекистаны баруун хойд хэсэгт хулгайн антай тэмцэх чухал ажлыг

гүйцэтгэдэг Амударьийн мэргэжлийн хяналтын багийнханы материал-техникийн басыг сайжруулах төсөл. Хулгайн ан бөхөнгийн Устюртийн популяцийн сэргэлтэд саад болж буй үндсэн аюул.

3. Татьяна Каримова (Россия). Фитолитүүдийн анализын инвазив бус аргыг ашиглан бөхөнгийн тэжээлийн судалгааг гүйцэтгэнэ. Дэлхэцийн оросын хэсэгт халимагийн заримдаг цөлд том хэмжээний хээржилт явагдаж буй учраас доминант болж буй үетэн ургамлуудыг бөхөн идэхгүй байх аюул бий учраас энэ маш чухал судалгаа юм. Иймээс популяцийн сэргэх потенциалыг ихэсгэхийн тулд бэлчээрийн менежментэд өөрчлөлт ч шаардлагатай байж болно.

БХХ 2009 онд ЖТХ-ийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг идэвхтэй хайж байна. Хэрвээ та болон таны танилууд ивээн тэтгэгчээр оролцох эсвэл дараа жилийн уралдааны тухай мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй доорх хаягаар mail@saiga-conservation.com холбогдоно уу. Илүү мэдээллийг та www.saiga-conservation.com сайтнаас олж болно.



Шарагчин
Зургийг Б.Бүүвэйбаатар



ШИНЭ ХЭВЛЭЛҮҮД

Арылова Н.Ю. Халимаг дахь бөхөнгийн популяци доройтсон нөхцөл дэхь бөхөнгийн нөхөн үржлийн онцлогууд // Поволжский экологийн сэтгүүл. 2008. № 2. х. 136 – 141.

Хэвлэлийн бүтээл болон өөрийн ажиглалтын дүнгээр тоо толгой багассан нөхцөлд бөхөнгийн европын популяцийн нөхөн үржлийн үзүүлэлтүүдийн судалгааг явуулсан (20 мянгаас бага бодгальтай). Амьдрах орчны нөхцөл муудаж, хөдлөлзүйн бүтэц алдагдсан, тоо толгой хэтэрхий багассан хэдий ч шинэ төрсөн янзагануудын хувь өнгөрсөн зууны 50-аад оны сүүлч үед тухайн популяци тоо толгойн хувьд дээд хэмжээндээ (800 бодгалиас дээш) хүрч байсан үеийн үзүүлэлтээс бараг ялгаагүй байгааг харуулжээ.

Бушман Л.Н., Варганова Е.П., Темираглы Р.А., Шаймуханбетов О.К. Төрөлх хязгаарын гайхамшиг. Сурагчидад зориулсан сурах бичиг. Редакторууд Я. Диркс, М.Г. Жиркова, Е.А. Быкова, А.В. Есипов. Ташкент, 2008. 35 х.



Каракалпак хэл дээр сурагчдад зориулсан бөхөнгийн тухай «Төрөлх хязгаарын гайхамшиг» сурах бичиг хэвлэгдэн гарлаа. Номыг 5000 хувь хэвлэж Каракалпакстанын ардын боловсролын ямаар батлуулсан. Энэ нь 2006 онд казах болон орос хэлээр Казахстанд хэвлүүлсэн дээрх зохиогчдын “Казахстаны тал нутгийн гайхамшиг” бөхөнгийн тухай номыг Каракалпакстаны нөхцөлд зохицуулсан шинэ хувилбар юм. Номыг NABU BAG “Eurasia” болон FFI –ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр бөхөн хамгаалах альянсийн узбекийн салбараас хэвлүүлсэн. Одоогоор номыг Каракалпакстанын сурагчдын дунд, эхний ээлжинд Устюртийн өндөрлөгийн Кунград районд амьдардаг хүүхдүүдийн дунд тараахад бэлэн байгаа. Ном нь сурагчдад шинэ мэдлэг, тал нутгийн байгалийн цогцын салшгүй хэсэг бөхөнгийн тухай төсөөллийг бий болгох, энэ ховор зүйлийг хэрхэн хамгаалах тухай мэдлэг олж авахад хүүхдүүдэд туслана.

Есипов А.В., Быкова Е.А., Черногаев Е.А. «Сайгачий» байгалийн нөөц газрыг шинээр зохион байгуулах шаардлагатай тухай асуудалд // Узбекистанын ТХГН дахь биологийн олон янз байдлыг хамгаалах асуудлууд. ШУ-практикийн хурлын материалууд Нукус, 2008. Х.39-42.

Абатуров Б.Д., Ларионов К.О., Джапова Р.Р., Колесников М.П. Халимагийн Черные земли дахь ургамалжилтын сэргэх үеийн нөхцөлд дэхь бөхөнгийн тэжээлийн хангамж ба тэжээлийн тоо хэмжээ. // Зоологический журнал, 2008, т.87, № 12. х. 1524-1530.

Ларионов К.О., Джапова Р.Р., Розенфельд С.Л., Абатуров Б.Д. Ургамалжилтийн сэргэх шатны болон ядуурах үеийн нөхцөлд Халимагийн Черные земли гийн бэлчээрт бөхөнгийн идэш тэжээл. // Зоологический журнал, 2008, т.87, № 10. Х. 1259-1269.

Бөхөнгийн хэрэглэж буй тэжээлийн ургамлын бүрэлдэхүүнийг жилийн туршид Халимагийн Черные земли дархан газарт судалсан. Кутикулярно-копрологическийн анализын аргыг ашиглан 96 бодгалийн тэжээлийг дүгнэн шинжилсэн. Одоогоор Черные земли гийн бөхөн тархсан нутгуудад хялгана мэтийн (80%) нэг талт үрт ургамлууд зонхилж байна. Бөхөн илүү сонгодог хоёр талт ургамлууд (хуурайсаг заримдаг сөөгөнцөрүүд, алаг өвс) бага (10%) эзэлж байна. Бөхөнгийн тэжээлд нэг талт ургамлууд зонхилж, тэдний хувь улирлаас хамаарахгүйгээр 56 хувийг бүрдүүлж байна. Бэлчээрийн ургамлан бүрхэвчиндэх үндсэн тэжээлийн ургамлын бага нөөц нь бөхөнгийн тэжээлд тэдний бага оролцоо эсвэл бүр байхгүй байх шалтгаан болж байна. Өвлийн улиралд бөхөнгийн бэлчээрлэлт намар эсвэл дулаахан өвлийн үед идэвхтэй ургаж, шатсан нутгуудад байна.

МакКонвилл А.Дж., Грачев Ю.А., Киан А., Коулсон Т., Бекенов А.Б., Милнер-Гулланд Э.Дж. Хэтэрхий аюулд өртсөн зүйлүүдийг илрүүлэх магадлалын өөрчлөлтийн засварт орох ажиглалтын явцыг шинээр сэргээх нь. *Endangered Species Research* 6, 2008. Х. 231-237.

Шийдвэрийн үр дүнтэй хүлээн авалт нь популяцийн хандлагын магадтай үнэлгээ байхыг шаарддаг. Мониторингийн аргууд удаан хугацааны туршид ашиглагддаг учраас харьцангуй элбэгшлийн хандлагууд бодит дүр зургийг харуулдаг гэж ихэнхдээ таамагладаг. Гэвч, хэрвээ харьцангуй элбэгшлийн үнэлгээний нарийвчлалгүй байдал, хазайлт цаг хугацаанд өөрчлөгдөөд байвал мониторингийн хөтөлбөрийн хүчинтэй байдалд айттар нөлөөтэй байх болно. Агаарын тооллогын мэдээгээр бөхөнгийн элбэгшлийн үнэлгээндэх алдаа, хазайлтын ретроспектив үнэлгээнд зориулж загвар боловсруулсан. Нягтшил, сүргийн хэмжээ эрс багассаны улмаас элбэгшлийн одоогийн үнэлгээ бодит популяцийн хэмжээнээс нэлээд бага байх магадлалтай, харин эдгээр үнэлгээний нарийвчлалгүй байдлын түвшин нь мониторингын хандлагад тэднийг ашиглахгүйд хүргэдэг. Энэ нь байгаль орчны хамгааллын зорилтуудын биелүүлтийн дэвшлийг ажиглах төлөвлөгөөнд Казахстаны засгийн газрын хувьд ач холбогдолтой. Сүргийн хэмжээ, харьцангуй элбэгшлээр түүхэн мэдээллүүд бүхий зүйлүүдэд энэ аргыг өргөн хэрэглэх боломжтой.

Бүрэн текстийг <http://www.int-res.com/articles/esr2008/6/n006p231.pdf> сайтнаас олох боломжтой.

Манай байгууллагын гишүүд

“Бөхөнгийн мэдээний” энэ дугаараас эхлэн дугаар болгон дээр бид бөхөн хамгаалах холбооны гишүүн байгууллагуудыг тэдний байгууллагын танилцуулга, бөхөнд хандах тэдний сонирхолыг танилцуулахаар урих болно. Энэ дугаарт бид “CIC Wildlife” бөхөн хамгаалах холбооны хамгийн анхны гишүүн байгууллагыг танилцуулж байна. Хэрвээ танай байгууллага БХХ-ны гишүүн болохыг хүсвэл хүсэлтээ mail@saiga-conservation.com хаягаар илгээнэ үү. Та бүхэнд “Бөхөнгийн мэдээ”-гээр өөрсдийгөө танилцуулах боломж бий болох, түүнчлэн энэ сэтгүүл болон манай интернэт хуудсан дээр мэдээгээ байршуулах боломжтой болно.

Зэрлэг байгаль агнуурын зүйлийг хамгаалах олон улсын зөвлөл- International Council for Game and Wildlife Conservation (CIC)



Төв-европийн санаачлагаар 1900 оноос эх үүсэлтэй Зэрлэг байгаль агнуурын зүйлийг хамгаалах олон улсын зөвлөл 1928 онд Палариково хотод (Словакия) байгуулагдсан. Тэр цагаас хойш зэрлэг байгалийг хамгаалах тогтвортой ашиглах чиглэлээр чухал зөвлөл болон ихээхэн нэр хүндтэй болсон.

CIC улс төрөөс хамааралгүй зөвлөх байгууллага бөгөөд Австрийн засгийн газраас олон нийтийн төлөө ажилладаг олон улсын засгийн газрын бус, худалдааны бус байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн. 2003 оноос CIC Вена хотноо албан ёсоор байрлах болсон.

Гишүүн байгууллагууд болох улсын байгууллага бүтцүүд, засгийн газрын бус байгууллага, нийгэмлэгүүд, их сургууль, хүрээлэнгүүдийг нэгэн дээвэр дор нэгтгэж, 84 орны 32 улсын байгууллагыг гишүүнээр нэгтгэсэнээрээ CIC өвөрмөц ховор юм. CIC –ийн захиргааны офис нь Будапешт байрлах бөгөөд гишүүдийн үйл ажиллагааг дэмжих, анхаарал төвлөрүүлэх комиссын бүтэцтэй байна.

Янз бүрийн зөвшилцөл, конвенцийн дагуу CIC засгийн газар хоорондын статустай болсон. 2004 онд CIC нь CMS–тэй бөхөнгийн асуудлаар харилцан ойлголцлын тунхаглалд гарын үсгээ зуралцсан, харин 2007 онд SCA–ийн гишүүн байгууллага болсон. Гишүүн байгууллагын хувиар CIC нь өөрийн танил холбоо, нөлөө, зөвлөх боломжуудаа ашиглан онцгой чухал зүйл болох бөхөнгийн төлөвийг сайжруулахын төлөө БХХ–д туслах болно.

Зарлал

Биологич-агнуурзүйчдийн олон улсын XXIX конгресс Москва хотноо болно.



ОХУ-ын Москва хотод 2009 оны 8-р сарын 17-22–ны хооронд агнуур зүйчдийн дэлхийн холбооны томоохон чуулга – биологич-агнуур зүйчдийн олон улсын XXIX конгресс болох гэж байна (IUGB). Янз бүрийн улс орнуудад 50 гаруй жилийн туршид хоёр жил тутам IUGB болдог. XXIX Конгрессийн үндсэн зорилго нь биологийн нөөцийн зөв зохистой, гамтай ашиглалттай холбоотой шинжлэх ухааны асуудлыг шийдэхэд болон

биологийн нөөцийг удирдах шинэ арга технологудтай танилцахад дэлхийн томоохон эрдэмтдийг татахад оршино. IUGB–ийн XXIX олон улсын конгрессийн хүрээнд янз бүрийн сэдвээр 18 салбар ажлуудыг төлөвлөсөн. “Агнуурын аж ахуй – амьтны ертөнцийг хамгаалах чухал хэрэгслүүдийн нэг” ерөнхий сэдвийн дор нэгтгэгдсэн нийтийн хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг, бага хурал болно.

Энэ жилийн конгрессийн тусгай сэдэв “Бөхөн хамгаалах асуудалд олон улсын хамтын ажиллагаа” бидний хувьд онцгой ач холбогдолтой байна. Бөхөн хамгаалах Альянс конгрессийн ажилд оролцоно гэж итгэж байгаа бөгөөд одоогоор удирдах гишүүдэд санхүүжилт хайж байна. Конгрессийн хүрээнд SCA-ийн жил бүрийн зөвлөлгөөнийг хийхээр төлөвлөж байна. Иймээс энэ өдрүүдийг өөрийнхөө тэмдэглэлийн дэвтэрт тэмдэглэж авна уу! Конгрессийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг авах, бүртгэлтэй танилцахыг хүсвэл www.iugb-moscow2009.ru сайт руу орно уу.

Джона Гиббсийн дурсгалд

Бөхөн хамгаалах Альянс 2008 оны төгсгөлд бидний анхны бөгөөд байнгын хандивлагчдын нэг Джона Гиббсийн нас барсанд гашуудал илэрхийлж байна. Түүний бөхөн болон байгаль хамгаалах үйл хэргийн баримтлал нь түүний ер бусын хичээл зүтгэл, байгаль хамгааллын янз бүрийн байгууллагад (манай гишүүн бөгөөд хандивлагч байгууллага FFI-д байсан) хамаардаг байснаар илэрч байсан. Бид түүнд энэ бүхнийх нь төлөө талархдаг.

Талархалууд

Сүүлийн 6 сарын турш бидний үйл ажиллагааг янз бүрийн хэлбэрээр дэмжиж байсан дараах хүмүүст бөхөн хамгаалах Альянс үнэхээр талархаж байна: Мэги Брайнт, Винса Мартин ба Зэрлэг Байгалийн Фонд, Джуди ба Чака Ветли, Кеннон ба Боб Хадсон, Линда Табор-Бек, Мишель Хакетт, Джефф Флокен, Энн Мэри Бургуин ба Бред Робертс, Глория ба Кент Маршалл, Марджори Паркер, Стивен ба Карин Чейз, Гэвин Эванс, Майкл Бромберг, Кэрролл Энн Ходджес, Ким ба Кевин Никейнн, Джойс Монтфорт ба Джесик Кулер болон бөхөн хамгаалахад хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст талархаж байна. Бид энэ дугаарыг гаргахад дэмжлэг үзүүлсэн, CMS, WCN ба Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар зэрэг байгууллагуудад талархаж байна.



Бөхөн хамгаалах харилцан ойлголцлын санамж бичгийн (MoB) гүйцэтгэлийн тухай SCA

2006 оны 9-р сараас 2008 оны 10-р сар хүртлэх хугацаанд CMS-ийн бөхөн хамгаалах
MoB-ийн гүйцэтгэлийн тайлан

Алмата хотноо CMS-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2008 оны 10-р сарын 29 нд SCA-ийн зөвлөлгөөн боллоо. Зөвлөлгөөн бүх хүмүүст нээлттэй байсан бөгөөд сүүлийн хоёр жилийн хугацаанд (2006 оны 9-р сараас 2008 оны 10-р сар хүртэл) дунд хугацааны олон улсын ажлын хөтөлбөрийн гүйцэтгэлийн ололтыг дүгнэх зорилт тавьсан. Энэ тоймын гол хэсгүүдийг доор харуулав. Бүрэн эхийг нь www.saiga-conservation.com хуудаснаас үзээрэй.

Бөхөн амьдрах дэлхэц нутгийн хүрээнд

1. *Гүйцэтгэл:* MoB-ийн үр дүнтэй гүйцэтгэлийн хэд хэдэн алхамууд хийгдсэн боловч улс орнуудын хувьд ялгаа байна. ОХУ одоо болтол MoB-д гарын үсгээ зураагүй ч зурна гэж хүлээгдсээр байгаа. Харилцаанууд ерөнхийдөө сайн байгаа. Амжилтаа цааш нь ахиулахад олон улсын зохицуулгын механизмыг байгуулбал маш хүчтэй нэмэр болох байх. Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах холбоо энэ хариуцлагыг авбал бид их дэмжинэ гэсэн санаа ч хэлэгдэж байсан.

2. *Хулгайн антай хийх тэмцэл:* бүх л орнуудад хулгайн антай тэмцэж байгаа боловч ахиц нь жигд бус, олонх нь хоорондоо холбоогүй, бас санхүүжилт дутуу дулимаг. Стратеги зорилтоо биелүүлэхэд нэмэр болох тусгайлсан асуудлаа шийдэхэд эсвэл аль нэг бүс нутгийн хэмжээнд хулгайн антай тэмцэх төлөвлөгөөг бүрэн хэмжээнд боловсруулсан нэг ч улс алга байна. Хулгайн ан одоо болтол бөхөнгийн гол аюул болсон хэвээр байгаа учраас цаашдын хүчээ яаралтай оруулах хэрэгтэй.

3. *Тогтвортой ашиглалт ба худалдаа:* Энэ хэсэгт багахан дэвшил тэмдэглэгдсэн ч энэ чиглэлийн ажлын хангалтгүй түвшин рүү анхаарлаа яаралтай хандуулах шаардлагатай.

4. *Хүний хүчин зүйл:* Бөхөнд хандах хүний хандлагыг судлах судалгаануудыг үргэлжлүүлсэн байна. Хүмүүсийн анхаарлыг татах, орлогын өөр эх үүсвэрүүдийг хөгжүүлэх жижиг төслүүдийг сорьж үзсэн боловч тэд нь одоогоор явцын шатандаа байна. Нутгийн иргэдийн хүсэлт шаардлагыг тооцож үзсэн томоохон хэмжээний төслийг хөгжүүлэх шаардлагатай. Зөвхөн ийм хандлагыг ашиглах тохиолдолд л хулгайн ангийн түвшинд нөлөөгөө үзүүлэх болно. Үндэсний түвшинд байгалийн бэлчээрээ тогтвортой ашиглах түүнд хариуцсан хүмүүсийг идэвхтэй татан оролцуулж төлөвлөлт явуулах шаардлагатай байна.

5. *Ухуулга, тайлбар:* Сүүлийн хоёр жилийн туршид нутгийн иргэдтэй ихээхэн ажил хийгдсэн. Энэ хэсэгт нэлээд амжилт олон.

6. *Тархацын зураглал:* ямар нэгэн тодорхой үр дүн гараагүй боловч энэ хэсэгт ажил эхэлсэн бөгөөд дараагийн зөвлөлгөөний үеэр дүн гарах байх.

7. *Тусгай хамгаалалтай нутгууд:* Зарим нэгэн ахиц Бетпақдала болон Монголын популяцийн орших нутгуудад гарсан. Энд үргэлжлүүлэн ажиллах хэрэгтэй бөгөөд зохион байгуулж буй хамгаалалтай нутаг дэвсгэрүүд үр дүнтэй байхын тулд зохих шинжлэх ухааны ажлуудыг явуулах шаардлагатай (6-р зүйлд заасан). Иймээс бүх авч байгаа арга хэмжээнүүд нь шинжлэх ухааны үндэслэлтэй байхын тулд энэ чиглэлд болгоомжтой урагшлах хэрэгтэй.

8. *Мониторинг:* мониторингийн хөтөлбөрүүд үргэлжилж байгаа бөгөөд зарим нэгэн шинэ хандлагуудыг (жишээ нь хамтын мониторинг) ашигласан байна. Гэвч одоо болтол илүү орчин үеийн арга зүй ашиглан аль ч популяцийн бодитой тооллого явагдаагүй байна. Одоо бид бөхөнгийн мониторингид орчин үеийн хандлагуудын тухай илүү ихийг мэдэх боловч тэднийг байнгын, уялдуулсан мониторингийн хөтөлбөрт нэгтгэхийн тулд бидэнд урагшаа ахиц шаардлагатай байна. Дунд хугацааны ажлын хөтөлбөрийн үндсэн зорилгын биелэлтийн хэмжээг үнэлэх үнэлгээнд мониторингийн тодорхой хөтөлбөрийг хөгжүүлэх шаардлага орсон байдаг болохоор энэ нь онцгой чухал юм.

9. *Үржүүлэг:* энэ хугацаанд ямар нэгэн ололт байсангүй, Халимагийн зэрлэг амьтны төв сайн хөгжиж байгаа, харин монголын хувьд энэ зорилтын биелүүлэх боломжын талаар үнэлгээ хийгдсэн.

Тодорхой популяцуудыг хамарсан арга хэмжээнүүд

10. *Баруун хойд Каспий орчмын популяци:* Олон сэтгэгдэл төрүүлсэн байгаль хамгааллын арга хэмжээнүүд явагдсан боловч ахицад улстөр, захиргааны тогтворгүй байдал, улсаас том хэмжээний санхүүгийн урсгал дэмжлэг байхгүй байгаа нь саад болж байна. Ажлаа голдуу богино хугацааны төслийн санхүүжилтээр гүйцэтгэж байна.

11. *Уралийн популяци:* харьцангуй анхаарал дутагдалтайгаас энэ популяци бас л хэцүү байгаа. Энэ популяцид тусгайлсан төсөл хэрэгждэггүй, төлөв байдлын талаар, ялангуяа хүний хүчин зүйлийн нөлөөллийн талаар мэдээлэл маш ховор байна. Популяци тогтвортойг гэрчилсэн эрдэм шинжилгээний мониторинг тодорхой хэмжээнд явагддаг. Улсаас санхүүжин хулгайн анчидтай тэмцдэг. Гэвч энэ хэсэгт хамгааллын арга хэмжээнүүдийг зохион байгуулах нь хамгийн урьтал ажил болж байна.

12. *Устюртийн популяци:* хулгайн ан маш их явагддаг, одоо ч байгаа, үүнээс болж тоо толгой буурахад хүргэж байгаа учраас ихээхэн анхаарал татаж байна (тоо толгой нь буурч байгаа гэж тэмдэглэсэн ганц популяци). Популяцийн төлөвийн тухай мэдээлэл хангалтгүй (ялангуяа шилжилт хөдөлгөөний экологийн асуудлаар). Одоогоор тархацын казахын хэсэгт хүмүүс рүү чиглэсэн төсөл хийгдэхгүй байгаа. Нутгийн иргэд рүү чиглэсэн байгаль хамгааллын ажлууд Үзбекистанд хийгддэг боловч жинхэнэ хамгааллыг зохион байгуулахад мөнгө хүрэлцэхгүй байна. Энэ популяци нь яаралтай оролцооны урьтал болж байна.

13. *Бетпақдалын популяци:* Сүүлийн хэдэн жил энэ популяцийн хамгаалалтанд улсаас, олон улсаас болон үндэсний ТББ-аас нэлээд санхүүжилт гарч байгаа. Популяцийн төлөвийг сайжруулахад энэ нь хувь нэмэр болж байна (мониторингийн хөтөлбөрийг сайжруулахгүйгээр энийг нарийн тогтоогдохгүй байж мэднэ).

14. *Монголын популяци:* энэ популяци үндэсний болон олон улсын ТББ-гаас нэлээд санхүүжилт авдаг учраас одоогоор түүний хөгжлийн хандлага, хамгийн сүүлд төлөвийн үнэлгээ хийгдсэн үетэй харьцуулахад илүү сайн байна. Монголд бөхөнг үржүүлэх нь ач холбогдол багатай бөгөөд түүнийхээ оронд байгаль дээрх үйл ажиллагаанд (*in situ*) санхүүжилтээ нэмэгдүүлэх нь илүү дээр байх болох нь харагдаж байна. Энэ шийдвэрийн тойм хэлбэрийг явуулах нь сайн бөгөөд энэ тохиолдолд шаардлагатай үед Дунд хугацааны ажлын гүйцэтгэлийн зохих заалтуудын урьталуудыг бууруулж болох юм.